

**НҮҮРСНИЙ АНГИЛАЛ, ЭКСПОРТ БА ЗАХ ЗЭЭЛИЙН ҮНЭ, ТАТВАРЫН ХУВЬ
ХЭМЖЭЭНИЙ ТАЛААРХ ЗАРИМ ОРНЫ ТУРШЛАГА**
(НҮҮРСНИЙ ЭКСПОРТООР ТЭРГҮҮЛЭГЧ ОРНУУДЫН ТУРШЛАГА, ХАРЬЦУУЛСАН СУДАЛГАА)

:

*Ц. Норовдондог (Ph.D), Д. Мягмарцэрэн, Ц. Батдорж, Г. Билгээ, Ц. Болормаа,
Г. Гэрэл, Б. Дуламсүрэн, Б. Нарантуяа, Ч. Онончимэ*

Агуулга

Оршил

Нүүрсний ангилал болон экспортын талаарх ерөнхий мэдээлэл

- Монгол Улс
- Австрали Улс
- Америкийн Нэгдсэн Улс
- Индонез Улс
- Оросын Холбооны Улс
- Өмнөд Африкийн Бүгд Найрамдах Улс
- Бүгд Найрамдах Хятад Ард Улс

Ашигласан материал

Хавсралт 1. ОХУ -ын экспортын барааны гол нэрийн бараа

* * *

ОРШИЛ

УИХ -ын эрхэм гишүүн Д.Ганхуягийн 2012 оны 5 дугаар сарын 11-ний өдрийн 7/3400 тоот албан бичгээр ирүүлсэн захиалгын дагуу Судалгааны төвийн эдийн засгийн судалгааны баг тус судалгааг хийж гүйцэтгэв. Судалгаанд захиалагчийн хүсэлтийн дагуу нүүрс олборлолт болон экспортын хэмжээгээр тэргүүлэгч улс орнуудаас Австрали, АНУ, Индонез, ОХУ, Өмнөд Африк, Хятад улсуудыг сонгон авч нүүрсний ангилал, нөөц, экспортын хэмжээ, экспортын болон бусад татварын хувь хэмжээ зэрэг асуудлын хүрээнд Монгол Улсын нүүрсний экспортын өнөөгийн байдалтай харьцуулан авч үзсэн болно.

НҮҮРСНИЙ АНГИЛАЛ БОЛОН ЭКСПОРТЫН ТАЛААРХ ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

Дэлхийн нүүрсний холбооны (World Coal Association) мэдээлснээр одоогийн нүүрс үйлдвэрлэх түвшнээр тооцоход дэлхийн 70 орчим оронд 118 жилийн нүүрсний нөөц байна гэж тогтоосон. Дэлхийн нүүрсний хүрээлэн (World Coal Institute) дэлхийн нүүрсний нийт нөөцийн хэмжээг 14.6 триллион тонн гэж тооцоолсон байна. Харин дэлхийн нүүрсний жилийн хэрэглээ ойролцоогоор 5.3 тэрбум тонн байдаг ба үүний 1.7 тэрбум тонн нь Хятад улсад оногдогоос хамгийн том хэрэглэгч хэмээгддэг байна. Бараг энэ хэмжээний нүүрс хэрэглэдэгээрээ Энэтхэг улс хоёрдугаарт жагсдаг.

Урьдчилсан тооцоогоор Энэтхэг-Хятадын хойгийн бүс нутаг 2025 он гэхэд хамгийн том хэрэглэгч болох магадлал өндөр байгаа бөгөөд дээрх улсууд тус бүрдээ ойролцоогоор жилдээ 2.7 тэрбум тонн нүүрс хэрэглэдэг болно хэмээн таамаглаж байгаа юм. Дэлхийн

нүүрсний хэрэглээний дундаж өсөлт 1.6 хувь байх магадлалтай. Нийт нүүрсний зах зээл Атлантын ба Номхон далайн гэсэн үндсэн хоёр хэсэгт хуваагддаг. Атлантын бүсэд ӨАБНУ, Колумби, ОХУ, Польш, АНУ гэсэн дарааллаар гол нийлүүлэгч байдаг бол Номхон далайн бүсэд Австрали, БНХАУ, Индонези, ОХУ багтдаг. Харин импортын хэмжээгээр Атлантад ХБНГУ, Англи, Испани, Итали, ОХУ гэсэн дараалалтай байдаг,

Номхон далайн бүсэд Япон, Өмнөд Солонгос, Тайван, Энэтхэг гэсэн улсууд байдаг. Энэ хоёр зах зээл экспортлох тээврийн зардлаараа харьцангуй ялгаатай байдаг ба Атлантын зах зээл дээрх нүүрсний үнийг ӨАБНУ-ын Ричард Бэй боомтын спот үнээр индикатор болгон тогтоодог бол Номхон далайн зах зээлийн үнийг Австралийн Ньюкастлын спот үнээс хамааруулан тогтоодог.

Хүснэгт 1. Дэлхийн нийт нүүрсний үйлдвэрлэл (сая тонн)

| | 1990 он | 2009 он | 2010 он |
|----------------------------------|---------|---------|---------|
| Дэлхийн нийт нүүрсний үйлдвэрлэл | 4677 | 6823 | 7229 |
| Чулуун нүүрсний үйлдвэрлэл | 3493 | 5789 | 6185 |
| коксжуулсан нүүрс | 598 | 782 | 891 |
| эрчим хүчний нүүрс | 2894 | 501 | 5294 |
| хүрэн нүүрсний үйлдвэрлэл | 1184 | 1033 | 1042 |

Хүснэгт 2. Дэлхийн шилдэг чулуун нүүрс үйлдвэрлэгч 10 улсууд (сая тонн, 2010 он)

| Улс | Нийт (сая тонн) | Улс | Нийт (сая тонн) |
|-------------|--------------------|-----------|--------------------|
| Хятад | 3162 | Орос | 248 |
| АНУ | 932 | Индонез | 173 |
| Энэтхэг | 538 | Казакстан | 105 |
| Австрали | 353 | Поланд | 77 |
| Өмнөд Африк | 255 | Колумб | 74 |

Хүснэгт 3. Дэлхийн шилдэг хүрэн нүүрс үйлдвэрлэгч улсууд (сая тонн, 2010 он)

| Улс | Нийт (сая тонн) | Улс | Нийт (сая тонн) |
|----------|--------------------|--------|--------------------|
| Герман | 169 | АНУ | 65 |
| Индонез | 163 | Грек | 56 |
| Орос | 76 | Поланд | 56 |
| Турк | 69 | Чех | 44 |
| Австрали | 67 | Серби | 37 |

Хүснэгт 4. Дэлхийн шилдэг нүүрс экспортлогч улсууд (сая тонн, 2010 он)

| Улс | Нийт (сая тонн) | Эрчим хүчний нүүрс (сая тонн) | Коксжих нүүрс (сая тонн) |
|-------------|--------------------|----------------------------------|-----------------------------|
| Австрали | 298 | 143 | 155 |
| Индонез | 162 | 160 | 2 |
| Орос | 109 | 95 | 14 |
| АНУ | 74 | 23 | 51 |
| Өмнөд Африк | 70 | 68 | 2 |

Дэлхийн гол нүүрс үйлдвэрлэгч улсуудын тоонд Хятад, Америк, Энэтхэг, Австрали, Индонез, Орос, Өмнөд Африк зэрэг улсууд орно. Олон улсын түвшинд нүүрсийг ерөнхий 4 ангилдаг

- Хүрэн нүүрс (эрчим хүчний, дулааны нүүрс /Lignite, Brown coal/)
- Хагас битумжсан нүүрс (Эрчим хүчний)
- Битумжсан нүүрс (Коксжих)
- Антрацит (Сайн чанарын коксжих нүүрс, илчлэг өндөртэй, чулуун нүүрс /Hard coking coal/)

Хүснэгт 5. Олон улсын нүүрсний ангилал

| Class or Rank | Group | Fixed Carbon ^(b) (wt % dry mmf) | | Volatile Matter ^(b) (wt % dry mmf) | | Gross Heating Value ^(c) (MJ/kg moist mmf) | |
|---------------|---|---|-----------|--|--------------------|---|-----------|
| | | Equal or greater than | Less than | Greater than | Equal or less than | Equal or greater than | Less than |
| Anthracitic | Metaanthracite ^(d) | 88 | | | 2 | | |
| | Anthracite ^(d) | 92 | 88 | 2 | 8 | | |
| | Semianthracite ^(d) | 86 | 92 | 8 | 14 | | |
| Bituminous | Low-volatile bituminous ^(d) | 78 | 86 | 14 | 22 | | |
| | Medium-volatile bituminous ^(d) | 69 | 78 | 22 | 31 | | |
| | High-volatile A bituminous | | 69 | 31 | | 32.55 | |
| | High-volatile B bituminous | | | | | 30.23 | 32.55 |
| | High-volatile C bituminous ^(d) | | | | | 26.74 | 30.23 |
| Subbituminous | Subbituminous A | | | | | 24.41 | 26.74 |
| | Subbituminous B | | | | | 22.09 | 24.41 |
| | Subbituminous C | | | | | 19.30 | 22.09 |
| Lignite | Lignite A | | | | | 14.65 | 19.30 |
| | Lignite B | | | | | | 14.65 |

(a) This classification does not include a few coals (referred to as unbanded coals) having unusual physical and chemical properties falling within the fixed carbon and heating value ranges of the high-volatile bituminous and subbituminous ranks.

(b) Percentage by weight on a dry and mineral matter free basis (mmf).

(c) Gross Heating Value on a moist and mineral matter free basis. Moist refers to the natural inherent water contained in a coal but does not include visible water (if any) on the surface of the coal. Multiply MJ/kg by 430.11 to convert to Btu/lb.

(d) Coals containing 69 wt % or more fixed carbon on a dry mmf basis are ranked according to their fixed carbon content regardless of their Gross Heating Value.

(e) A high-volatile C bituminous coal that may be agglomerating or non-agglomerating.

(f) A high-volatile C bituminous coal that is an agglomerating coal, which means that it tends to become sticky and to cake when heated. The agglomerating character of a coal is determined by heating a sample to 950 °C under certain conditions. If the residue is coherent and supports a weight of 500g without pulverizing, the coal is classified as being agglomerating.

1. МОНГОЛ УЛС

Манай улсын хувьд одоогоор зөвхөн Хятад руу нүүрсээ экспортлож байгаа бөгөөд нөгөө талаар нүүрсэнд эцсийн боловсруулалт хийлгүйгээр экспортлодог тул нүүрсээ тодорхой төрлөөр нь нарийвчилсан ангилал байхгүй. Мөн тэрхүү ангилал тус бүрээр нь ялгавартай оноосон үнэ байхгүй тул экспортлох нүүрсний үнийг хүлээн авагч тал болох Хятадын импортлож байгаа нүүрсний үнийг жишиг болгон тогтоодог байна.

Харин нүүрсний үнийн талаарх мэдээллээ **Coalworld.net** сайтаас авдаг. Тиймээс манай улсын экспортын нүүрсний үнэ болон ангиллын талаарх үндсэн үзүүлэлтийг харуулахын тулд ЭБЭХЯ-ын сайтан дээр байршуулсан БНХАУ-ын импортлосон коксжих нүүрсний үнэ, дотоод зах зээл дээрх нүүрсний үнэ болон бусад холбогдох мэдээллүүдийг орууллаа.

Хүснэгт 6. БНХАУ-ын импортлосон коксжих нүүрсний үнэ

| Гарал үүсэл | Хил боомт | Үнэ /юань/ тн/ | Үнслэг % | Дэгдэмхий % | Хүхэр % | Бөсөх чадвар G | Тодруулга | Төрөл |
|-------------|---------------------|----------------|----------|-------------|---------|----------------|------------------|---------------------|
| Монгол | Ганц мод | 1210 | 10,5 | 28 | <0,6 | 83 | Агуулах дахь үнэ | Хатуу коксжих нүүрс |
| | Овоот толгой уурхай | 270 | 18-20 | 30-33 | 1,3 | 32 | Уурхай дахь үнэ | Сул бөсөх нүүрс |
| | | 320 | 12-14 | 30-33 | 1-1,2 | 46 | Уурхай дахь үнэ | 1/2 коксжих нүүрс |
| | | 430 | 8-10 | 30-33 | <1 | 69 | Уурхай дахь үнэ | 1/3 коксжих нүүрс |
| | Сэхээ | 600 | 8-10 | 30-33 | <1 | 69 | Агуулах дахь үнэ | 1/3 коксжих нүүрс |
| | | 600 | <12 | 35-36 | <1 | 65 | Агуулах дахь үнэ | 1/3 коксжих нүүрс |

Эх сурвалж: Саус Гоби Энэржи Ресурс, sxcoal.com/ Coalworld.net 2012-05-07)

Хүснэгт 6. 2012 оны 05-р сарын 07-ны байдлаарх Анхуй муж дахь нүүрсний үнэ

| Муж | Бүс нутаг | Нүүрсний төрөл | Илчлэг / ккал/кг/ | Бусад үзүүлэлтүүд | Үнийн төрөл | Үнэ /юань/ тонн буюу ам.дол/тн/ |
|-------|-----------|------------------------------|-------------------|--|--|---------------------------------|
| Анхуй | Хуайбэй | 1/3 коксжих нүүрс | | Дэгдэмхий 30% Хүхэр 0,2% Үнслэг 9,5% Бөсөх чадвар 88 | Төмөр замын өртөөн дэх үнэ /НӨТ орсон/ | 1500=238\$ |
| Анхуй | Хуайбэй | Ядмаг нүүрс Угаасан нүүрс | | Дэгдэмхий 13,8% Хүхэр 0,4% Үнслэг 11% Бөсөх чадвар 60 | Төмөр замын өртөөн дэх үнэ /НӨТ орсон/ | 1550=246\$ |
| Анхуй | Хауайнан | Эрчим хүчний нүүрс | 5500 | Дэгдэмхий 25% Хүхэр 0,6% Үнслэг 19% | Төмөр замын өртөөн дэх үнэ /НӨТ орсон/ | 760=120\$ |

| | | | | | | |
|-------|----------|-------------------|------|--|---|------------|
| Анхуй | Хауайнан | 1/3 коксжих нүүрс | | Дэгдэмхий 30% Хүхэр 0,5% Үнслэг 9-10% Бөсөх чадвар 84 | Төмөр замын өртөөн дэх үнэ /НӨТ орсон/ | 1638=260\$ |
| Анхуй | Сузхоу | Зөөлөн нүүрс | 5000 | Дэгдэмхий 25% Хүхэр <1% Үнслэг 21% | Төмөр замын өртөөн дэх үнэ /НӨТ орсон/ | 710=113\$ |

Эх сурвалж: CCTD/ Coalworld.net 2012-05-07) 1 ам.доллар=6.31 юань

Хүснэгт 7. 2012 оны 05-р сарын 07-ны байдлаархи Шаньси муж дахь нүүрсний үнэ

| Муж | Бүс | Нүүрсний төрөл | Хувилбарууд | Ичлэг / Ккал/кг/ | Бусад үзүүлэлтүүд | Үнийн төрөл | Үнэ /юань/ тонн буюу ам.дол/ тонн/ |
|--------|---------|--------------------|---------------------------------|---------------------|---|--|--|
| Шаньси | Гужиао | Коксжих нүүрс | | | Хүхэр: 1,3%, дэгдэмхий: 16%-22%, үнслэг:<8%, бөсөх чадвар >70 | Төмөр замын өртөөн дэх үнэ /НӨТ орсон/ | 1440=228\$ |
| Шаньси | Гужиао | Коксжих нүүрс | | | Хүхэр: 0.6%, дэгдэмхий: 16%-22%, үнслэг:<10%, бөсөх чадвар >73 | Төмөр замын өртөөн дэх үнэ /НӨТ орсон/ | 1600=254\$ |
| Шаньси | Тайюань | Ядмаг нүүрс | | | Хүхэр: 1% дэгдэмхий: 12%-18%, үнслэг:<10%, бөсөх чадвар: 5-15 | Төмөр замын өртөөн дэх үнэ /НӨТ орсон/ | 1000=158\$ |
| Шаньси | Чангзи | Ядмаг нүүрс | | | Хүхэр: 0.3%, дэгдэмхий: 16%, слэг:<11%-12%, бөсөх чадвар >40 | Төмөр замын өртөөн дэх үнэ /НӨТ орсон/ | 1280=203\$ |
| Шаньси | Датонг | Эрчим хүчний нүүрс | | 6000 | Хүхэр: 0.8%, дэгдэмхий: 28%-32%, үнслэг:<10%, | Уурхайн аман дахь үнэ /НӨТ ороогүй/ | 555=88\$ |
| Шаньси | Датонг | Эрчим хүчний нүүрс | | 5500 | Хүхэр: 0.8%, дэгдэмхий: 28%-32%, үнслэг:<10% | Уурхайн аман дахь үнэ /НӨТ ороогүй/ | 530=84\$ |
| Шаньси | Янгкуан | Антрацит | Бутархай нүүрс | 6200 | Хүхэр: <1%, дэгдэмхий: 7%- 9%, слэг:<14- 169%, | Уурхайн аман дахь үнэ /НӨТ ороогүй/ | 690=109\$ |
| Шаньси | Янгкуан | Антрацит | Дунд хэмжээтэй угаасан нүүрс | 7000 | Хүхэр: <1%, дэгдэмхий: 7%-9%, үнслэг:<9-12%, | Уурхайн аман дахь үнэ /НӨТ ороогүй/ | 1050=166\$ |

Судалгааны эмхтгэл, XIII боть

| | | | | | | | |
|--------|---------|----------|-------------------------------|------|--|-------------------------------------|------------|
| Шаньси | Янгкуан | Антрацит | Жижиг хэмжээтэй угаасан нүүрс | 7000 | Хүхэр: <1%, дэгдэмхий: 7%-9%, үнслэг:<9-12%, | Уурхайн аман дахь үнэ /НӨТ ороогүй/ | 995=158\$ |
| Шаньси | Жинчэнг | Антрацит | Бутархай нүүрс | 6000 | Хүхэр: 0,3%, дэгдэмхий: 14%, үнслэг:7-8%, | Уурхайн аман дахь үнэ /НӨТ ороогүй/ | 730=116\$ |
| Шаньси | Жинчэнг | Антрацит | Жижиг хэмжээтэй угаасан нүүрс | 6500 | Хүхэр: 0.6%, дэгдэмхий: 16%-22%, үнслэг:<10%, бөсөх чадвар >73 | Уурхайн аман дахь үнэ /НӨТ ороогүй/ | 1600=254\$ |
| Шаньси | Жинчэнг | Антрацит | Дунд хэмжээтэй угаасан нүүрс | 6800 | Хүхэр: 0.5%, дэгдэмхий: 14%-22%, үнслэг:6%, | Уурхайн аман дахь үнэ /НӨТ ороогүй/ | 1125=178\$ |

Хүснэгт 8. 2012 оны 05-р сарын 07-ны байдлаархи Өвөр Монголын өөртөө засах бүс дэх нүүрсний үнэ

| Муж | Бүс | Нүүрсний төрөл | Илчлэг /ккал/кг/ | Бусад үзүүлэлтүүд | Үнийн төрөл | Үнэ /юань/ тонн буюу ам.дол/тонн |
|--------------------------------|------------|----------------------------|------------------|---|--|----------------------------------|
| Өвөр Монголын өөртөө засах бүс | Чифэнг | Зөөлөн нүүрс | 4000 | Дэгдэмхий:42%, Үнслэг:<25%, Хүхэр :0.7% | Уурхай дахь үнэ (НӨТ орсон) | 500= 79 \$ |
| Өвөр Монголын өөртөө засах бүс | Баотоу | Эрчим хүчний нүүрс | 5000 | Үнслэг :20%, Дэгдэмхий :30%, Хүхэр :0.2% | Төмөр замын өртөөн дэх үнэ (НӨТ орсон) | 430= 68 \$ |
| Өвөр Монголын өөртөө засах бүс | Эрдос | Эрчим хүчний нүүрс | 6000 | Дэгдэмхий:31%, Үнслэг:<5%, Хүхэр:<0.4%, Бөсөх чадвар>83 | Уурхай дахь үнэ (НӨТ орсон) | 460= 73 \$ |
| Өвөр Монголын өөртөө засах бүс | Хөлийн гол | Хүрэн нүүрс | 3500 | Дэгдэмхий:46%, Үнслэг:25%, Хүхэр:<0.5%, Бөсөх чадвар>83 | Уурхай дахь үнэ (НӨТ орсон) | 270= 43 \$ |
| Өвөр Монголын өөртөө засах бүс | Вухай | Тост нүүрс (угаасан нүүрс) | | Дэгдэмхий :29.4%, Үнслэг :10%, Хүхэр: 2%, Бөсөх чадвар >96 | Төмөр замын өртөөн дэх үнэ (НӨТ орсон) | 980=155 \$ |
| Өвөр Монголын өөртөө засах бүс | Вухай | Тост нүүрс (угаасан нүүрс) | | Дэгдэмхий: 32%, Үнслэг :10%, Хүхэр:1.8%, Бөсөх чадвар>94 | Төмөр замын өртөөн дэх үнэ (НӨТ орсон) | 1030=163 \$ |

| | | | | | | |
|--------------------------------|-------|----------------------------|--|--|--|-------------|
| Өвөр Монголын өөртөө засах бүс | Вухай | Хагас зөөлөн коксжих нүүрс | | Дэгдэмхий :30%, Үнслэг :7%, Хүхэр: 1.1%, Бөсөх чадвар >83 | Төмөр замын өртөөн дэх үнэ (НӨТ орсон) | 1030=163 \$ |
|--------------------------------|-------|----------------------------|--|--|--|-------------|

(Эх сурвалж :CCTD/CoalWorld.net 2012-05-07) 1 ам. доллар=6.31 юань

Хүснэгт 9. 2012 оны 05-р сарын 07-ны байдлаархи Ша'аньси муж дахь нүүрсний үнэ

| Муж | Бүс | Нүүрсний төрөл | Илчлэг (ккал/кг) | Үнийн төрөл | Бусад үзүүлэлтүүд | Үнэ (юань/тонн буюу ам.долл/тонн) |
|----------|-----------|---------------------|------------------|--|---|-----------------------------------|
| Ша'аньси | Юлин | Эрчим хүчний нүүрс | 6000 | Уурхай дахь үнэ (НӨТ орсон) | Хүхэр:<1%, Дэгдэмхий: 33%-35%, Үнслэг:15% | 540=86 \$ |
| Ша'аньси | Шэнмү | Зөөлөн нүүрс | 6500 | Төмөр замын өртөөн дэх үнэ (НӨТ орсон) | Хүхэр:<0.8%, Дэгдэмхий: 32%-36%, Үнслэг:10% | 730=116 \$ |
| Ша'аньси | Ксиан'ан | Зөөлөн нүүрс | 6000 | Төмөр замын өртөөн дэх үнэ (НӨТ орсон) | Хүхэр: 0.6%, Дэгдэмхий: 35%, Үнслэг:14% | 770=122 \$ |
| Ша'аньси | Хуанглинг | Эрчим хүчний нүүрс | 6000 | Төмөр замын өртөөн дэх үнэ (НӨТ орсон) | Хүхэр:0.5%, Дэгдэмхий: 32%, Үнслэг:26-32% | 550=87 \$ |
| Ша'аньси | Тонгчуан | Хатуу коксжих нүүрс | | Төмөр замын өртөөн дэх үнэ(НӨТ орсон) | Хүхэр:1,7%, Дэгдэмхий: 20%, Үнслэг:10%, | 1230=195 \$ |
| Ша'аньси | Тонгчуан | Угаасан ядмаг нүүрс | 5000 | Төмөр замын өртөөн дэх үнэ(НӨТ орсон) | Хүхэр: <0.8%, Дэгдэмхий: 18%, Үнслэг :10%, | 1185=188 \$ |

(Эх сурвалж: CCTD /CoalWorld.net 2012-05-07) 1 ам. доллар=6.31 юань

Хүснэгт 10. 2012 оны 05-р сарын 07-ны байдлаархи Шандун муж дахь нүүрсний үнэ

| Муж | Бүс нутаг | Нүүрсний төрөл | Илчлэг (ккал/кг) | Бусад үзүүлэлтүүд | Үнийн төрөл | Үнэ (юань/тонн буюу ам.доллар/тонн) |
|--------|-----------|-----------------------------|------------------|---|--|-------------------------------------|
| Шандун | Зибо | Ядмаг нүүрс (холимог нүүрс) | 5000 | Дэгдэмхий:16%, хүхэр:<1.2%, үнслэг: 33-34% | Төмөр замын өртөөн дэх үнэ (НӨТ орсон) | 720=114 \$ |

| | | | | | | |
|--------|-----------|----------------------------|-------------------|--|---|-------------|
| Шандун | Зибо | Хийт нүүрс | Бөсөх чадвар: 70 | Дэгдэмхий: 37.8%, хүхэр: 0.4%, үнслэг: 11% | Төмөр замын өртөөн дэх үнэ (НӨТ орсон)) | 1100=174 \$ |
| Шандун | Заозхуанг | Тост нүүрс (угаасан нүүрс) | Бөсөх чадвар: >86 | Дэгдэмхий: 33.3%, хүхэр: 2.3%, үнслэг: 9% | Төмөр замын өртөөн дэх үнэ (НӨТ орсон) | 1460=231 \$ |
| Шандун | Заозхуанг | Эрчим хүчний нүүрс | 5500 | Дэгдэмхий: 30%, хүхэр: <1.5 %, үнслэг: 18% | Төмөр замын өртөөн дэх үнэ (НӨТ орсон) | 880=139 \$ |
| Шандун | Янзхоу | Эрчим хүчний нүүрс | 6000 | Дэгдэмхий: 30%, хүхэр: 0.7%, үнслэг: 14-6% | Төмөр замын өртөөн дэх үнэ (НӨТ орсон) | 900=143 \$ |
| Шандун | Тенгзхоу | Эрчим хүчний нүүрс | 5500 | Дэгдэмхий: 32%, хүхэр: 0.8%, үнслэг: 17-20% | Уурхайн ам дахь үнэ | 780=124 \$ |

(Эх сурвалж: CCTD/ Coalworld.net 2012-05-07) 1 ам.доллар=6.31 юань

2. АВСТРАЛИ УЛС

Нүүрсний ангилал

Австрали улсын нүүрсний ангилалыг дэгдэмхийн агуулга, илчлэг, үнслэг, чөлөөт хөөлтийн зэрэг болон грей-кинг гэсэн нүүрсний чанарын дөрвөн үзүүлэлтээр ангилсан мэдээллийг ЭБЭХЯ-аас 2010 онд гаргасан “Нүүрсний тухай мэдээлэл” -ээс ишлэн оруулав.

Нүүрсний экспорт

Нүүрс бол чулуужсан түлш бөгөөд дэлхийн нийт эрчим хүчний үйлдвэрлэлийн 27 хувийг эзэлдэг. Атомын найрлагийн ихэнхи хувь нь устөрөгчийн болон нүүрстөрөгчийн хий байх бөгөөд маш бага хэмжээний хүхэр болон бусад элемент эзэлдэг.

Хар нүүрс нь Австралийн хамгийн том экспортийн бүтээгдэхүүн бөгөөд Австралийн бүтээгдэхүүн худалдааны салбарын 16 хувийг эзэлж байна. Австрали улс нь дэлхийн хэмжээнд дөрөв дэх том нүүрс үйлдвэрлэгч (Хятад, АНУ болон Энэтхэгийн дараа орох) бөгөөд хамгийн том экспортлогч юм. Дэлхийн нүүрсний худалдааны ойролцоогоор 27 хувийг Австрали улс нийлүүлж байна. (дэлхийн металлургийн нүүрсний худалдааг оролцуулан) 2008 онд Австралийн коксжих нүүрсний экспортын 70 гаруй хувь, эрчим хүчний нүүрсний 94 хувийг Азийн бүс нутагт экспортолсон байна. Нүүрсний худалдааны салбарт тэргүүлсэн энэ байр суурь нь Австралийн чанартай нүүрсний нөөц болон хэрэглэгчдэд танигдсан, хариуцлагатай, өндөр чансаатай нүүрсний үйлдвэр дээр суурилан олон жилийн турш нүүрсний худалдааг өргөжүүлсэнтэй холбоотой юм.

Хүснэгт 11. Австралийн нүүрсний ангилал

| | Код | Дэгдэмхийн агуулга (dmmf, %) | Илчлэг (daf, MJ/kg) | | Код | Грей – Кинг |
|------------------------|-----|------------------------------|---------------------|----------------------------|-----|-----------------------|
| 1-р хэсэг (coal class) | 1 | <10.0 | | 3-р хэсэг (coal sub group) | 0 | A |
| | 2 | 10.1 – 14.0 | | | 1 | B – D |
| | 3 | 14.1 – 20.0 | >33.82 | | 2 | E – G |
| | 4A | 20.1 – 24.0 | 32.02– | | 3 | G1 – G4 |
| | 4B | 24.4 – 28.0 | 33.82 | | 4 | G5 – G8 |
| | 5 | 28.1 – 33.0 | 25.43 – | 4-р хэсэг (ash number) | 5 | G9 |
| | 6 | 33 – 41 | 32.02 | | Код | Үнслэг (dry basis, %) |
| | 7 | 33 – 44 | 27.08 – | | (0) | <4.0 |
| | 8 | 35 – 50 | 28.42 | | (1) | 4.1 – 8.0 |
| | 9 | 42 – 50 | | | (2) | 8.1 – 12.0 |
| | Код | Чөлөөт хөөлтийн зэрэг | | | (3) | 12.1 – 16.0 |
| 2-р хэсэг (coal group) | 0 | 0 – S | | | (4) | 16.4 – 20.0 |
| | 1 | 1 – 2 | | | (5) | 20.1 – 24.0 |
| | 2 | 2S – 4 | | | (6) | 24.1 – 28.0 |
| | 3 | 4S – 6 | | | (7) | 28.1 – 32.0 |
| | 4 | 6S – 9 | | | (8) | >32 |

Австралийн хар нүүрсний үйлдвэрлэлийн хүчин чадал нь тус улсын эдийн засгийн нөөцөд 100 шахам жил хангалттай хэмжээний дэмжлэг үзүүлэхээр байна. Харин хүрэн нүүрсний үйлдвэрлэл нь ойролцоогоор 400 шахам жилийн хугацаанд эдийн засгийн нөөцөд дэмжлэг үзүүлэхээр байгаа талаар “Австралийн нүүрсний холбоо”-оос судалгаа гаргасан байна.

2007-2008 оны санхүүгийн жилд Австралийн хар нүүрсний үйлдвэрлэлийн бүтээгдэхүүн хамгийн их худалдаалагдсан буюу 326.8 сая тонн байсан бол 2009-2010 онд 320.7 сая тонн болж буурсан тооцоо гарсан байна. Энэ бууралт нь дэлхийн эдийн засгийн бууралттай салшгүй холбоотой бөгөөд тэр дундаа дэлхийн боловсруулаагүй гангийн үйлдвэрлэл болон Азийн цахилгааны эрэлт хэрэгцээ багассан нь голлох хүчин зүйл болжээ.

Австралийн нүүрсний экспорт (эрчим хүчний болон коксжих) нь 2007-2008 онд 24.4 тэрбум австрали долларийн өртөг бүхий 252.0 сая тонн, 2009-2010 онд 28.4 тэрбум австрали долларын өртөг бүхий 250.5 сая тонн болон буурсан байна. 2008 оны дэлхийн эдийн засгийн бууралтын үр дүнд эрчим хүчний нүүрсний гэрээгээр тогтворжуулсан үнэ 57 хувиар, коксжих нүүрсний гэрээгээр тогтворжуулсан үнэ 55 хувиар тус тус бууруулсан бөгөөд эдгээр нь түүхэн өндөр үнэ болжээ.

2008 онд Австралийн экспортын бүтээгдэхүүний шилдэг импортлогчид нь: Япон улс - экспортын бүтээгдэхүүний 47 хувь, БНСУ 15 хувь, Европийн Холбоо 10 хувь, Тайван 10

хувь, Энэтхэг 10 хувь тус тус импортлосон байна.⁴⁷ 2006 оноос 2010 оны хугацаан дахь Австралийн эрчин хүчний болон коксжих нүүрсний нийт үйлдвэрлэлийн хэмжээ, түүнээс хичнээн хувийг нь хэрэглэгч улс орнууд руу экспортолсон болон экспортын бүтээгдэхүүний тухайн жилийн нийт өртгийн хэмжээг он оноор нь харьцуулсан үзүүлэлтийг доорх хүснэгтээр үзүүлээ.

Хүснэгт 12. Австралийн нүүрсний экспортын 2006 - 2010 оны харьцуулсан үзүүлэлт⁴⁸

| Санхүүгийн жил | 2006-2007 | 2007-2008 | 2008-2009 | 2009-2010 |
|------------------------------------|-----------|-----------|-----------|-----------|
| Бүтээгдэхүүн сая тонн(Mt): | | | | |
| Эрчим хүчний нүүрс /Thermal Coal/ | 181.1 | 185.1 | 200.5 | 190.7 |
| Коксжих нүүрс /Metallurgical Coal/ | 142.6 | 140.1 | 135.4 | 136.3 |
| Экспорт сая тонн(Mt): | | | | |
| Эрчим хүчний нүүрс /Thermal Coal/ | 115.6 | 115.1 | 130.5 | 122.5 |
| Коксжих нүүрс /Metallurgical Coal/ | 132.0 | 137 | 119 | 128 |
| Нийт | 243.6 | 252.1 | 249.5 | 250.5 |
| Экспортын өртөг (Ав.долл.тэрбум): | | | | |
| Эрчим хүчний нүүрс /Thermal Coal/ | 6,758 | 8,365 | 17,589 | 9,815 |
| Коксжих нүүрс /Metallurgical Coal/ | 15,039 | 16,038 | 34,464 | 18,628 |
| Нийт | 21,797 | 24,403 | 52,053 | 28,443 |

Австралийн хүрэн нүүрсний үйлдвэрлэлийн дийлэнхийг Викториа мужийн Латробийн Хөндийгөөс олборлож байгаа бөгөөд 2007 оноос 2008 онд 72,4 сая тонн хүрэн нүүрс үйлдвэрлэсэн бөгөөд хүрэн нүүрсийг дотоодын эрчим хүчний үйлдвэрлэлд ашигладаг байна. Австралийн цахилгааны эх үүсвэрийн 83 хувийг хар болон хүрэн нүүрс бүрдүүлдэг. Хар нүүрсний үйлдвэрлэлд 2007 оны байдлаар ойролцоогоор 31,000 ажилчид ажиллаж байгаа гэсэн статистик мэдээлэл гарсан байна.

в) Татвар.

Австралийн татварын тогтолцооноос уул уурхайн салбарт хамаарах дараах төрлийн татварууд байна. Үүнд:

- Орлогын албан татвар
- Нөөцийн түрээсийн татвар /роялти/
- Онцгой албан татвар
- Нэмэгдсэн өртгийн албан татвар /Бүтээгдэхүүн үйлчилгээний татвар/
- Суутгалын татвар
- Өндөр ашгийн татвар /уул уурхайн татвар/ зэрэг татварын төрлүүд хамаарахаар байна.

Австралийн татварын тухай хуульд "Income Tax Assessment Act 1997", "Income Tax Rates Act 1986" зааснаар орлогын албан татвар, суутгалын татвар болон бусад татварыг ногдуулахдаа тус улсын иргэн болон, харъяат бус гадаадын иргэн, аж ахуйн нэгжээр нь ялгамжтай ногдуулдаг байна. Харин нөөцийн төлбөрийн хувьд хувийн болон төрийн уурхай гэсэн үзүүлэлтээр ялгамжтай тогтоодог байна.

- Орлогын албан татвар нь хувь хүн болон харъяатын хувьд орлогын хэмжээнээс шалтгаалан ялгамжтай ногдуулдаг байна. Харин компанийн орлогын албан татвар нь 30 хувь байхаар тогтоосон байна.

⁴⁷ http://www.ret.gov.au/resources/mining/australian_mineral_commodities/Pages/australia_coal_inx

⁴⁸ ABARE Australian Commodities, June Quarter 2009 ' ABARE forecast

- b) Нөөцийн түрээсийн татвар буюу Роялтийн хувьд байгалийн ямар төрлийн ашигт малтмал олборлож байгаагаас шалтгаалан өөр өөр хувь хэмжээгээр ногдуулдаг байна. Нүүрсний үйлдвэрлэлийн хувьд 5 хувийн роялти тогтоодог байна. “Ашигт малтмалын нөөцийн түрээсийн татварын тухай хууль”⁴⁹ нь 2011 онд шинэчлэгдэн батлагдсан байна.
- c) Нэмэгдсэн өртгийн албан татвар нь бүтээгдэхүүн үйлчилгээнд
- d) Суутгалын татвар нь “Орлогын татвар ногдуулах тухай хууль”-ийн 128 (B)-д зааснаар:
- ❖ Ногдол ашигт-30 хувь
 - ❖ Хүүгийн орлогод-10 хувь
 - ❖ Роялтид- 30 хувиар тус тус татвар ногдуулдаг байна.
- e) Өндөр ашгийн татвар буюу Super profit tax. 2012 оны 7 сараас эхлэн тус улсад роялтиг өндөр ашгийн татвар гэж нэрлэхээр болсон байна. Энэ татвар нь үйлдвэрлэгчийн болон судлаачдын зүгээс нилээд шүүмжлэл дагуулж байгаа бөгөөд уул уурхайн компаниудын төрд төлөх роялтийн хэмжээг ойлгомжгүй болгосон гэж үздэг байна. Ашигтай ажиллаж буй ямар ч уул уурхайн компани 6 хувиас дээш баялагийн хөрөнгө оруулалттай бол 40 хувийн татвар төлөхөөр тогтоосон байна.

3. АМЕРИКИЙН НЭГДСЭН УЛС

- **Нүүрсний нөөц:** Эрчим хүчний төв /Energy information administration/-өөс АНУ-лсыг 261 тэрбум тонн нөхөн сэргээгдэх нөөцтэй гэж мэдээлсэн байдаг. Энэ нь өнөөгийн нүүрсний хэрэглээний түвшингээр тооцоход ойролцоогоор 235 жил хүрэлцэхүйц нөөцтэй гэсэн үг юм. Дэлхийн нүүрсний нөөцийн 27 хувь нь АНУ -д ногддог бөгөөд Америкийн компаниуд хэрэгцээт нүүрснийхээ ихэнхийг удаан жилийн гэрээний үндсэн дээр авахаар тохиролцсон байдаг. Тус улсад 25 муж улсын газар нутагт 458,600 mile буюу нийт газар нутгийн 13 орчим хувиас нүүрс олборлож байна. Нийт нүүрсний 75 орчим хувийг Wyoming, West Virginia, Kentucky, Pennsylvania, Montana гэсэн 5 мужаас олборлож байна.
- **Нүүрсний экспортын хэмжээ:** АНУ-ын нүүрсний экспорт 2011 онд огцом өссөн бөгөөд энэ нь АНУ-ын хувьд дотоодын нүүрсний хэрэглээ буурч, харин Европ болон Азийн орнуудын хэрэглээ өссөнтэй холбоотой юм.

АНУ нь дэлхийд 4-р байранд буюу Австрали, Индонез, ОХУ-ын дараа орох нүүрс экспортлогч томоохон оронын тоонд зүй ёсоор ордог. Азийн орнуудад нүүрсний эрэлт нэмэгдсэнтэй холбоотой АНУ, БНХАУ уруу экспортолсон нүүрсний хэмжээ 2009-2010 онд огцом өссөн байна.

Хүснэгт 13. АНУ -ын нүүрсний нийт экспорт, импорт

| Он | Экспорт | Импорт | Нийт экспорт | Нийт өөрчлөлтийн хувь |
|------|---------|--------|--------------|-----------------------|
| 2005 | 49,942 | 30,460 | 19,482 | |
| 2006 | 49,647 | 36,246 | 13,401 | -31% |

⁴⁹ Minerals Resource Rent Tax Bill 2011.

| | | | | |
|------|---------|--------|--------|------|
| 2007 | 59,163 | 36,347 | 22,816 | 70% |
| 2008 | 81,519 | 34,208 | 47,311 | 107% |
| 2009 | 59,097 | 22,639 | 36,458 | -23% |
| 2010 | 81,716 | 19,353 | 62,363 | 71% |
| 2011 | 106,468 | 13,524 | 92,944 | 49% |

Хүснэгт 14. АНУ -ын нүүрсний экспорт, 2010 - 2011 оны улирлын харьцуулсан дүн

| Улс | Коксжуулсан | | Уураар боловсруулсан | |
|--------------------|-------------|-----------|----------------------|-----------|
| | 2010 | 2011 | 2010 | 2011 |
| Хойд Америк, нийт | 1,245,912 | 461,541 | 455,145 | 498,983 |
| Канад | 1,148,996 | 255,391 | 345,146 | 309,302 |
| Мексик | 96,916 | 182,610 | 77,133 | 118,640 |
| Бусад | 1,245,912 | 23,540 | 32,866 | 71,041 |
| Өмнөд Америк, нийт | 1,749,954 | 2,197,197 | 256,174 | 555,790 |
| Аргентин | 105,376 | 96,942 | 92 | 513 |
| Бразил | 1,644,578 | 2,100,255 | 1,332 | 138,871 |
| Чили | 0 | 0 | 249,470 | 410,929 |
| Бусад | 0 | 0 | 5,280 | 5477 |
| Европ, нийт | 6,583,322 | 7,781,356 | 1,522,002 | 4,931,208 |
| Бельги | 270,263 | 489,678 | 14,756 | 145,470 |
| Хорват | 227,709 | 391,359 | 0 | 148,073 |
| Дани | | | 0 | 84,689 |
| Франц | 242,785 | 356,916 | 329,366 | 494,908 |
| Герман | 348,098 | 546,809 | 166,314 | 899,009 |
| Итали | 616,834 | 903,957 | 127,541 | 222,999 |
| Латви | 105,490 | 42,782 | 0 | 78,337 |
| Нидерланд | 1,025,836 | 1,188,000 | 334,628 | 1,120,742 |
| Норвеги | 15,770 | 26,534 | 5,519 | 12,293 |
| Польш | 552,214 | 332,559 | 72,034 | 174 |
| Португал | 0 | 0 | 79,135 | 243,631 |
| Урмын | 214,673 | 423,328 | 0 | 0 |
| Словени | 166,946 | 233,840 | 0 | 0 |
| Испани | 288,714 | 399,710 | 142,077 | 155,104 |

| | | | | |
|----------------|------------|------------|-----------|-----------|
| Швед | 0 | 60,861 | - | - |
| Турк | 576,329 | 616,602 | 84,356 | 310,173 |
| Украин | 840,441 | 1,040,404 | 0 | 0 |
| Англи | 852,368 | 417,118 | 159,280 | 852,159 |
| Бусад | 238,852 | 310,899 | 6,996 | 163,447 |
| Ази, нийт | 3,468,257 | 6,334,652 | 1,317,392 | 2,364,013 |
| Хятад | 1,454,877 | 1,548,012 | 754,266 | 505,632 |
| Энэтхэг | 518,351 | 994,731 | 113 | 231,664 |
| Япон | 693,772 | 2,699,176 | 1,596 | 118,844 |
| Өмнөд солонгос | 772,567 | 772,567 | 471,908 | 1,501,091 |
| Африк, нийт | 229,975 | 390,711 | 77,088 | 935,565 |
| Египет | 81,203 | 243,961 | 4,271 | 163,357 |
| Морокко | 0 | 69,935 | 70,513 | 771,991 |
| Өмнөд Африк | 148,772 | 76,815 | 21 | 211 |
| Бусад | 0 | 0 | 2,283 | 6 |
| Дэлхийд нийт | 13,277,420 | 17,165,457 | 3,628,462 | 9,451,700 |

➤ АНУ-ын нүүрсний татварын хувь хэмжээ

АНУ-ын орлогын албан татварын тогтолцоо нь тухайн муж бүрээр харилцан адилгүй ялгаатай байдаг. Ашигт малтмалын төрлөөс хамааран татварын хөнгөлөлтийн хувь нь 5-22% хүртэл ялгаатай байдаг. Хэдийгээр АНУ-ын корпорацийн өрийн хувь 1.5-1.0-ээс хэтэрсэн байсан ч гадны хуулийн этгээдэд төлөх хүү хязгаарлагдсан байдаг.

Хүснэгт 15. АНУ -ын нүүрсний татвар, орлогын албан татвар хураамж

| | |
|--|--|
| Корпорацийн татвар | 35% нэмээд улсын орлогын татвар /олон улсын жишиг/ |
| Төлбөрийн татвар | 30% ноогдол ашиг, хүү, эрхийн төлбөр, техникийн туслалцаанд зориулагдах ба эс бөгөөс хүчин төгөлдөр бусад татварыг зохицуулагч дүрмээр хөнгөлөлтийг тооцно. |
| Уул уурхайн онцгой татвар | Улсаас тодорхой төрлийн эрдсүүдийн олборлолтонд татвар ноогдуулах ба энэ нь муж улс бүрт өөр өөр байдаг. |
| Татварын тогтвортой байдлын зохицуулга Татварын хөнгөлөлт | Тодорхойгүй. Энэ татварын хувийн бууралт нь "уул уурхайн салбараас олж буй үндэсний орлого"-ын хэмжээнд суурилан татварын хэмжээг бууруулах боломж олгодог ба улсаас хязгаарыг нь заасан байдаг. |

- **Нүүрсний үйлдвэрлэл:** АНУ 1980-2005 он хүртэл дэлхийн нүүрсний үйлдвэрлэлийн 20 орчим хувийг эзэмшиж ирсэн. 2010 онд дэлхийд 2-р байранд орохоор нүүрс үйлдвэрлэгч орон болсон ба дэлхийд томоохонд тооцогддог нүүрсний ордуудыг эзэмших болсон.

АНУ-ын нүүрсний үйлдвэрлэл 2010 онд 1,084.4 сая тонн буюу 2009 оны үйлдвэрлэлийн

Судалгааны эмхтгэл, XIII боть

хэмжээтэй ижил байна. Нүүрсний хэрэглээ 1,051.3 сая тонн буюу өмнөх оныхоос 5.1 хувиар өссөн бөгөөд энэхүү өсөлт нь цахилгаан станцууд, үйлдвэрлэлийн салбар, коксжуулалтын салбарын өсөлттэй холбоотой. АНУ-ын уурхайнуудын 30 орчим хувь нь улсын эзэмшлийнх ба нийт нүүрсний 75 орчим хувийг үйлдвэрлэдэг. Нүүрсний үйлдвэрлэлийн 2/3 орчим хувь нь гадаргуугийн уурхайгаас гаралтай байна.



Хүснэгт 16.

- АНУ -ын нүүрсний үнэ 2010, 2009 онд муж улс болон уурхайн төрлөөр (тонн, ам доллар)

| Coal-Producing State | 2010 | | | 2009 | | |
|----------------------|-------------|---------|-------|-------------|---------|-------|
| | Underground | Surface | Total | Underground | Surface | Total |
| Alabama | 88.55 | 82.09 | 86.15 | 76.58 | 75.35 | 76.10 |
| Alaska | - | W | W | - | W | W |
| Arizona | - | W | W | - | W | W |
| Colorado | W | W | 40.00 | W | W | 36.71 |
| Illinois | 50.19 | 45.24 | 49.46 | 48.43 | 45.62 | 47.97 |
| Indiana | 49.00 | 38.91 | 43.03 | 48.74 | 33.27 | 38.70 |
| Kansas | - | W | W | - | W | W |
| Kentucky Total | 60.69 | 61.07 | 60.84 | 58.85 | 58.09 | 58.54 |
| Eastern | 74.25 | 66.91 | 70.67 | 70.95 | 62.56 | 66.77 |
| Western | 45.34 | 35.36 | 43.38 | 40.81 | 32.26 | 39.07 |
| Louisiana | - | W | W | - | W | W |
| Maryland | W | W | 47.54 | W | W | 37.65 |
| Mississippi | - | W | W | - | W | W |
| Missouri | - | W | W | - | W | W |
| Montana | W | W | 15.12 | W | W | 13.53 |
| New Mexico | W | W | 30.67 | W | W | 30.71 |
| North Dakota | - | 14.57 | 14.57 | - | 13.59 | 13.59 |
| Ohio | 44.35 | 41.02 | 43.24 | 46.11 | 41.94 | 44.55 |
| Oklahoma | W | W | 56.95 | W | W | 56.45 |
| Pennsylvania Total | 62.58 | 62.17 | 62.51 | 55.61 | 54.84 | 55.48 |
| Anthracite | W | W | 59.51 | 56.83 | 57.12 | 57.10 |
| Bituminous | W | W | 62.59 | 55.61 | 54.44 | 55.44 |
| Tennessee | 65.57 | 66.83 | 66.45 | 79.83 | 56.84 | 66.05 |
| Texas | - | 20.32 | 20.32 | - | 19.12 | 19.12 |
| Utah | 29.15 | - | 29.15 | 32.32 | - | 32.32 |
| Virginia | 108.09 | 81.80 | 98.46 | 78.75 | 74.21 | 77.09 |

УИХ-ЫН
СУДАЛГААНЫ САН

Зураг 1. АНУ -ын нүүрсний үйлдвэрлэл 1950 - 2010 он (сая тонн)




- **Нүүрсний хэрэглээ:** Олборлож буй нийт нүүрсний 93 орчим хувь нь цахилгаан эрчим хүч үйлдвэрлэлд хүч үйлдвэрлэлд зориулагдах ба тодорхой хэмжээтэй нь бусад үйлдвэрлэлийн зорилгоор тухайлбал цемент үйлдвэрлэл, гангийн үйлдвэрт төмрийн хүдэр хайлуулах зуух галлахад зориулж коксжуулах зэрэгт хэрэглэгддэг. Бага хэмжээний нүүрс түүхийгээр шатааж нийтийн халаалт, цэрэг, гэр орны халаалтад хэрэглэдэг. АНУ-ын цахилгаан эрчим хүчний 50 орчим хувь нь нүүрсээр үүсгэгддэг бөгөөд 10 тонн нүүрс тус бүрийн 9 тонн орчим нь дотоодын цахилгааны хэрэглээнд зарцуулагддаг байна. АНУ-д жилд нэг хүнд ноогдох нүүрсний хэмжээ 3.4 тонн орчим байна.
- АНУ-ын нүүрсний хэтийн төлөв: Нүүрс ашиглан цахилгаан эрчим хүч үйлдвэрлэх үйлдвэрлэл 2035 оноос буурах хандлагатай. 2011 онд ерөнхийлөгч Брак Обама байгаль орчны дулааралд нөлөөлдөг нүүрсхүчлийн давхар исэл ялгаруулдаггүй эсвэл бага ялгаруулдаг эрчим хүчний эх үүсвэрт бид найдах хэрэгтэй хэмээн энэ талаар бодлого хэрэгжүүлэх тухай тэмдэглэсэн байна.

Нүүрсхүчлийн давхар исэл, бусад хүлэмжийн хийн нөлөөллөөс үүдэн хязгаарлалт

хийхгүй л бол өсөн нэмэгдэж буй хэрэглээгээр нь жилд хэрэглэж буй нүүрсний хэмжээ нэмэгдэх хандлагатай. Тиймээс хүлэмжийн хийн нөлөөлөлтэй холбоотой шинэ бодлого нь нүүрсний хэрэглээнд шууд нөлөөлөх боломжтой. Хэрэв Конгрес нүүрсхүчлийн давхар ислийн ялгаралтыг хянах, хязгаарлах хууль батлавал нүүрсний хэрэглээний үнэ өсөх юм. Цахилгаан эрчим хүчний компаниуд нүүрсхүчлийн давхар исэл бага ялгаруулдаг технологи нэвтрүүлэхийг эрхийлж байгаа бөгөөд эдгээрт цөмийн эрчим хүч, сэргээгдэх эрчим хүч, байгалийн хий зэрэг тооцогдож байна. Нүүрсийг агаар мандалд хүлэмжийн хий бага ялгаруулах байдлаар шатаах туршилт хийгдэж байгаа аж.

Зураг 2. АНУ -ын эрчим хүчний хэрэглээ, гол түлшний төрлөөр, 2010 он

Зураг 3. Эрчим хүч үйлдвэрлэхтэй холбоотой хуримтлагдаж буй нүүрсхүчлийн давхар исэл гол түлшний төрлөөр, 2010 он



Хүснэгт 17. АНУ-ын нүүрсний ангилал (ASTM)

| Ангилал | Бүлэг | Үзүүлэлтүүд (Минерал хольцгүйгээр) | | |
|----------------------|-------------------|------------------------------------|-------------------|-------------------------|
| | | Хатуу үлдэгдэл (FC, %) | Дэгдэмхий (VM, %) | Илчлэг (CV, maf btu/lb) |
| Антрацит | Мета-антрацит | > 98 | <2 | |
| | Антрацит | 92 – 98 | 2 – 8 | |
| | Хагас антрацит | 86 – 92 | 8 – 14 | |
| Битумжсэн нүүрс | Бага дэгдэмхий | 78 – 86 | 14 – 22 | |
| | Дунд дэгдэмхий | 69 – 78 | 22 – 31 | |
| | Өндөр дэгдэмхий А | 31 – 69 | >31 | >14'000 |
| | Өндөр дэгдэмхий В | | | 13'000 – 14'000 |
| | Өндөр дэгдэмхий С | | | 10'500 – 13'000 |
| Хагас бшумжсэн нүүрс | Хагас битумжсэнА | | | 10'500 – 11'500 |
| | Хагас битумжсэнВ | | | 9'500 – 10'500 |
| | Хагас битумжсэн С | | | 8'300 – 9'500 |

| | | | | |
|--------|----------|--|--|---------------|
| Лигнит | Лигнит А | | | 6'300 – 8'300 |
| | ЛигнитВ | | | <6'300 |

* * *

4. ИНДОНЕЗ УЛС

Индонез улсын 2010 оны эрчим хүчний статистик судалгаагаар 2009 оны эцэст 4328 сая тонн нүүрсний нөөцтэй байсан ба энэ нь дэлхийн нийт нүүрсний нөөцийн 0.52 хувийг эзэлдэг байна. Индонезын нүүрсний үйлдвэрлэл 20 гаруй жилийн түүхтэй ба 2004 оны 1 сараас эхлэн “Үндэсний Нүүрсний Бодлого”-ыг хэрэгжүүлж эхэлсэн.

Нүүрсний ангилал:

Индонезийн нүүрсний дийлэнх буюу 60 %-ийг хагас битумжсан нүүрс, 29 %-ийг лигнит нүүрс, харин үлдсэн 11 % -ийг битумжсан нүүрс эзэлдэг байна.

Хүснэгт 18. Индонезийн нүүрсний ангилал, нөөцийн хэмжээ

| Нүүрсний ангилал | Илчлэг чанар (kcal/kg) | | Нөөц сая тонн (gad) | | | Нийт % |
|-----------------------|------------------------|------------------|---------------------|------------|--------|--------|
| | GAD ¹ | GAR ² | Бодитой | Батлагдсан | Нийт | |
| Лигнит | <5100 | <4500 | 4,292 | 1,105 | 5,397 | 29% |
| Хагас битумжсан нүүрс | 5100-6100 | 4500-5800 | 8,214 | 2,971 | 11,185 | 60% |
| Битумжсан нүүрс | >6100 | <5800 | 744 | 1,385 | 2,129 | 11% |
| Нийт | | | 13,250 | 5,461 | 18,711 | 100% |

Эх сурвалж: Indonesian Coal Book, 2008/2009, ICMA, July 2008

Note: GAD¹ /Gross Air Dried/, GAR² /Gross As Received/

Нүүрсний татварын хувь хэмжээ:

Тус улсын нүүрс олборлолтын гэрээний хувьд татвар болон бусад холбогдох заалтыг тухайн гэрээнд гарын үсэг зурах үеийн нөхцөл байдлыг хэвээр хадгалах зарчим баримтална. Өөрөөр хэлбэл тухайн гэрээний хүчинтэй хугацаанд гэрээнд тусгасан татварыг тогтворжуулдаг ба харин уг гэрээгээр зохицуулаагүй бусад татварын хувьд тухайн үед хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа хуулиар зохицуулдаг байна.

Гэрээний хугацаа дуусахад нийтийн зориулалттай хөрөнгө /тухайлбал, зам, сургууль, эмнэлэг гэх мэт/ нь тухайн компанид нөхөн төлбөр олгогдохгүйгээр шууд Индонезийн Засгийн газрын өмч болон шилжинэ.

Лиценз эзэмшигчид нь бүтээгдэхүүний роялти буюу нүүрсний нөөц ашиглалтын төлбөр төлөх ба түүний хувь хэмжээ нь уул уурхайн талбай, үйлдвэрлэлийн түвшин, уул уурхайн бүтээгдэхүүний үнэ, уурхайн төрөл /ил уурхай болон далд уурхай/ зэргээс хамаарч төрөл бүр байна. Харин Тусгай уул уурхайн бизнесийн лиценз эзэмшигчид нь цэвэр ашгийн 10% -ийн нэмэлт роялтиг төлнө.

Хүснэгт 19. Нүүрсний нөөц ашиглалтын төлбөрийн хувь
(Засгийн газрын тогтоол 2000 оны №13)

| Нүүрсний уурхайн төрөл | Нүүрсний нөөц ашиглалтын төлбөрийн хувь хэмжээ | Илчлэг чанар | Хувь хэмжээ /%/ |
|------------------------|--|--------------|-----------------|
| Ил уурхай | 3%-7% | <5100 | 3.00 |
| | | 5100-6100 | 5.00 |
| | | >6100 | 7.00 |
| Далд уурхай | 2%-6% | <5100 | 2.00 |
| | | 5100-6100 | 4.00 |
| | | >6100 | 6.00 |

Хүснэгт 20. Нүүрс олборлолтын гэрээнд холбогдох татварууд /CcoW/

| № | Төрөл | | Хувь хэмжээ /%/ | |
|---|---------------------------------------|--|---|------------------------|
| 1 | Түрээсийн төлбөр – гектар бүрт USD | Ерөнхий судалгаа | 0.025 – 0.05 | |
| | | Хайгуул | 0.10 – 0.35 | |
| | | Үнэлгээ | 0.50 | |
| | | Барилга байгууламж/бүтээн байгуулалт | 0.50 | |
| | | Үйл ажиллагаа | 1.50 – 3.00 | |
| 2 | Нөөц ашигласны төлбөр /роялти/ | | 13.5% /Борлуулалтын үнээс борлуулалтын тодорхой зардлыг хасаж/ | |
| 3 | Аж ахуйн нэгжийн орлогын албан татвар | Татварын хувь хэмжээ | | Дээд тал нь 30% |
| | | Татвар хөнгөлөлтийн хэмжээ | Биет бус хөрөнгө: - Шулуун шугамын - Давхар буурах балансын | 10% -50% 20% - 100% |
| | | | Биет хөрөнгө: - Шулуун шугамын - Давхар буурах балансын | 10% -20% Байхгүй |
| | | Элэгдэлт - Шулуун шугамын - Давхар буурах балансын | | 10% -50% 20% - 100% |
| | | Татварын алдагдлын урагш шилжүүлэлт | | Найман жил |
| 4 | Орлогын албан татвар | Ногдол ашиг, ашиг, роялти | | 20% |
| | | Ногдол ашиг /үүсгэн байгуулагч,хувьцаа эзэмшигч/ | | 7,5% |
| | | Түрээсийн, техникийн, менежментийн төлбөр, бусад үйлчилгээний төлбөр | | 1,5%-20% |
| | | Ажилчдын орлогын албан татвар | | Байгаа |

| | | | |
|---|--------------------------------|---|--|
| 5 | Нэмэгдсэн өртгийн албан татвар | Нүүрсний борлуулалтын нэмэгдсэн өртгийн албан татвар | дотоодын борлуулалтанд 10%, экспортын борлуулалтанд 0% |
| | | Дотоодын худалдан авалтын НӨАТ | 10% /уул уурхайн компануудаас хураана/ |
| | | Импортын НӨАТ | Үйл ажиллагааны 10 дахь жил хүртэл чөлөөлөгдөнө |
| | | Гадаадын үйлчилгээний НӨАТ | 10% |
| 6 | Борлуулалтын татвар | | Байхгүй /1984 онд борлуулалтын татварыг хүчингүй болгосон/ |
| 7 | Барааны импортын татвар | | Одоо үйлчилж буй хуулинд заасны дагуу үйл ажиллагааны 10 дахь жил хүртэл чөлөөлөгдөнө. |
| 8 | Бусад татвар | Орон нутгийн татвар /машин тэрэг, замын татвар гэх мэт/ | Одоо үйлчилж буй хуулинд заасны дагуу мөрдөнө. |

Нүүрсний экспортын татвар:

Индонезийн Сангийн яамны 2005 оны 95 дугаар тогтоолд зааснаар нүүрсний экспортын татвар нь Гаалийн хураамжгүй (FOB) үнэд суурилсан 5% байсан боловч Сангийн сайдын 2006 оны 9 сарын 13-ны өдрийн №S-396/MK.10/2005 тогтоолд заасны дагуу нүүрс экспортлох хуулийн үйлчлэлийг хойшлуулсан байна.

Нүүрсний экспортын татварыг тооцох аргачлал:
5% * экспортын даац * FOB үнэ * валютын ханш


Харин 2012 оны 5 дугаар сарын 6-наас эхлэн Индонезийн Засгийн газар 14 нэр төрлийн эрдэс бүтээгдэхүүн түүхий эдийн экспортод 20%-ийн татвар ногдуулахаар тогтоосон байна. Тус улсын 2009 оны “Нүүрс болон бусад эрдэс баялгийн тухай” хуульд зааснаар бол 2014 оноос эхлэн Индонез нь “нөхөн сэргээгдэхгүй” баялгийг түүхий хүдрээр нь гаргахыг хориглохоор тусгасан байжээ. Индонез улсын хувьд уул уурхайн салбарт одоогийн байдлаар “Freeport-McMoran”, “Copper&Gold”, “Vale Indonesia”, “Aneka Tambang” болон “Antam” зэрэг томоохон компаниуд нүүрс олборлолтын гэрээ байгуулан ажиллаж байгаа юм. Салбарын яамны мэдэгдэж буйгаар эдгээр компанийн үйл ажиллагаанд дээрх нүүрсний экспортын татварын хууль хамаарахгүй ажээ.

Нүүрсний бүтээгдэхүүн үйлдвэрлэл болон экспортын хэмжээ:

Зураг 4-өөс харахад Индонезийн эрчим хүчний нүүрсний экспортын хэмжээ 1995 оноос хойш жил тутам тогтмол өссөн бөгөөд харин 2000 оноос хойш огцом өссөн үзүүлэлттэй байна. Харин дотоодын хэрэглээ маш бага өсөлттэй байх бөгөөд үүнээс харахад тус улс нь нүүрсний бүтээгдэхүүнийхээ 60-аас дээш хувийг экспортолдог байна.

Зураг 4.

- Индонезийн эрчим хүчний нүүрсний экспорт болон дотоодын хэрэглээ, 1995-2009 / сая тонн/ Ω



Хүснэгт 21.

- Нүүрсний үйлдвэрлэл болон экспорт, импортын хэмжээ, 2002 - 2009 (сая тонн)

| Жил | 2002 | 2003 | 2004 | 2005 | 2006 | 2007 | 2008 | 2009 |
|--------------|-------|-------|-------|-------|-------|-------|-------|-------|
| Бүтээгдэхүүн | 111.1 | 119.3 | 135.1 | 150.9 | 180.1 | 190.6 | 202.8 | 214.6 |
| Дотоод | 31.1 | 30.2 | 30.3 | 39.1 | 33.5 | 39.2 | 47.8 | 47.5 |
| Экспорт | 76.3 | 89.1 | 105.4 | 117.2 | 147.0 | 163.5 | 158.0 | 176.4 |

Source: Energy Publishing, "Indonesian Coal and Power Report" (various monthly issues from 2004 through February 2010)

Дээрх хүснэгтээс харахад тус улс нь 2009 онд 176,4 сая тонн нүүрсийг бусад улс оронд экспортолсон бөгөөд энэ нь 2002 оны 76,3 сая тонн үзүүлэлтээс 100,1 сая тонн буюу 43,2 хувиар өссөн байна. Мөн түүнчлэн Дэлхийн Нүүрсний Холбооны /World Coal Association/ мэдээлснээр Индонез улс нь 2010 онд нийт 173 сая тонн чулуун нүүрс болон 163 сая тонн хүрэн нүүрс олборлосон байна. Үүнээс 2010 онд 162 сая тонн нүүрс экспортолсноос 160 сая тонн нь эрчим хүчний нүүрс, 2 сая тонн нь коксжих нүүрс байсан байна. 2000-2009 оны хооронд Индонезийн нүүрсний салбарын бүтээгдэхүүн жилд дунджаар 12%-ийн өсөлттэй байсан байна.

Зах зээлийн үнэ ханш

Дэлхийн нүүрсний Newcastle (gcNEWC)-ийн индексээс харвал 2003 онд Азийн эрчим хүчний нүүрсний үнэ тонн нь 26 ам.долл байсан бол 2006 онд 49 ам.долл болон өссөн байна. Түүнчлэн энэ нь 2010 оны эхний найман сарын байдлаар 96 ам.долл болж өссөн нь 2006 оны ханшнаас 49 ам.долл-с бараг 2 дахин өссөн байна.

2012 оны 5-р сард Индонезийн коксжих нүүрсний үнэ 3.30% буурсан нь 2011 оны 1-р сараас хойших хамгийн доод түвшин юм. Индонезийн Эрчим хүч, байгалийн баялагийн яамнаас 2012 оны 5-р сард нүүрсний үнийг 102.12 ам.доллараар тогтоосон нь өмнөх сарын мөн үеэс 3.49 ам.доллараар буурсан байна. Тус яамнаас нүүрсний үнийг тооцохдоо нүүрсний илчлэг чанар (GAR) 6,322 kcal/kg (энэ нь коксжих нүүрсний ангилалд орно), нийт чийглэг

нь (arb) 8.00%, нийт хүхэр нь 0.8% (arb), үнс нь 15 % (arb) болон FOB үнэд суурилсан. Хүснэгт 22-т дурьдсан нүүрсний үнийг 2012 оны 5-р сарын 1-31-ний хооронд хийгдэх экспортод баримтлана.

Хүснэгт 22. Индонезийн нүүрсний үнэ (US\$/ MT)*, 2012 оны 5 сарын 8-ны байдлаар

| Large Scale Producers | |
|--|------------------------|
| 5000 GAR, TM 25% - FOB MV East Kalimantan*** | US\$ 70.50 |
| 5200 GAR, TM 24% - FOB MV South Kalimantan** | US\$ 73.00 |
| 5800 GAR, TM 16% - FOB MV East Kalimantan*** | US\$ 88.00 |
| | Medium Scale Producers |
| 5000 GAR, TM 25% - FOB MV South Kalimantan** | US\$ 70.00 |
| 5300 GAD, TM 42% - FOB MV Sumatera** | US\$ 40.00 |
| Note : * Subject to terms & conditions, disclaimer clause ** Anchorage Loading *** Coal Terminal Loading | |

Эх сурвалж: www.coalspot.com


Зураг 5. **DSP of SGX AsiaClear OTC дээрх нүүрсний солилцоо**
(2012 оны 4-р сарын 30-аас 5-р сарын 4)



Эх сурвалж: www.coalspot.com

Индонезийн Хагас битумжсан нүүрс 2012 оны 4-р сарын 30 буюу даваа гарагт нээхэд 76.52 ам.долл байснаас 5-р сарын 4 буюу Баасан гарагт 1.77 ам.доллар буюу 2.31% -аар буурч 74.75 ам.доллар болж хаагдсан байна.

Зураг 6. Индонез улсын уул уурхайн эрх зүйн зохицуулалт



Ашигт малтмал, нүүрсний уул уурхайн үйл ажиллагааг 2009 оны 1 сарын 12-ны өдрийн “№4/2009 Ашигт малтмал нүүрсний уурхайн хуулиар” /Law on Mineral and Coal Mining No 4/2009/ зохицуулна. Энэхүү хуулиар уул уурхайн олборлолтын гэрээ болон Нүүрс олборлолтын гэрээний /CoW, SsoW/ гадаадын хөрөнгө оруулалт, уул уурхайн лиценз, зөвшөөрөл зэрэг уул уурхайн салбарын бүхий л харилцааг зохицуулсан байна.

Уг хуулиар уул уурхай салбарын үйл ажиллагаа явуулах талбайг доорх байдлаар ангилна:

1. Уул уурхайн талбай /Commercial mining business areas/. Энэ нь томоохон хэмжээний уул уурхайн газар;
2. Улсын нөөцийн талбай /State reserve areas/. Энэ нь үндэсний стратегийн ашиг сонирхолд зориулсан нөөц газар;
3. Иргэдийн уул уурхайн талбай /People's mining areas/. Энэ нь орон нутгийн жижиг хэмжээний уул уурхайн газар;

Уул уурхайн лицензийг уурхайн байршил, байгалийн баялагаас нь хамааран гурван төрөл болгон ангилна. Үүнд:

- Уул уурхайн бизнесийн лиценз /IUP or Mining Business Licence/
- Тусгай уул уурхайн бизнесийн лиценз /IUPK or Special Mining Business Licence/
- Иргэдийн уул уурхайн лиценз /IPR or People's Mining Licence/ (гадаадын хөрөнгө оруулагч эзэмших эрхгүй)

Тусгай уул уурхайн бизнесийн лицензийг зөвхөн Индонез улсын иргэн эзэмших ба харин Уул уурхайн бизнесийн лицензийг гадаадын хөрөнгө оруулагч эсхүл Индонез улсын иргэн

эзэмшиж болно. Уул уурхайн бизнесийн лицензийг хайгуулын болон ашиглалтын гэж ангилна. Иргэдийн уул уурхайн лицензээр нийт 10,000 га-аас ихгүй талбайд уул уурхайн үйл ажиллагаа явуулахыг зөвшөөрдөг байна. Энэ хуулиар уул уурхайн чиглэлийн үйл ажиллагаа явуулах эрх бүхий компани нь зөвхөн нэг л лиценз эзэмшихийг зөвшөөрдөг бөгөөд харин зөвхөн Индонезын хөрөнгийн биржид бүртгэлтэй компанийн хувьд хэд хэдэн лиценз эзэмшихийг зөвшөөрдөг болно.

Хүснэгт 23. Уул уурхайн бизнесийн ашиглалтын лицензийг олгох

| Лиценз олгогч | Уурхайн байршил |
|---------------|---|
| Сайд | Нэг мужаас дээш газар нутгийг хамарч байвал |
| Мужын дарга | Хэд, хэдэн хот тосгоныг хамарсан гэхдээ нэг муж дотор бол |
| Хотын дарга | Нэг хот тосгоны дотор бол |

Уул уурхайн лицензийг шинээр олгохдоо тендер шалгаруулалтын дагуу ил тод шудрагаар сонгон шалгаруулдаг. Ийнхүү сонгон шалгаруулалтыг явуулахдаа уул уурхайн бизнесийн хайгуулын лицензийн тендерт гадаадын хөрөнгө оруулагчдыг оролцохыг зөвшөөрдөг бол харин тусгай уул уурхайн бизнесийн хайгуулын лицензийг зөвхөн тухайн улсын төрийн өмчит компаниудад олгодог байна. Хэрэв эдгээр уул уурхайн тусгай бүс газарт үйл ажиллагаа явуулах сонирхолтой Төрийн өмчит компани байхгүй бол, Эрдэс баялаг эрчим хүчний яам өрсөлдөөнт тендер шалгаруулах замаар хувийн хэвшлийн компаниудад олгож болдог байна.

Хүснэгт 24. Лицензийн хугацаа

| | Уул уурхайн бизнесийн хайгуулын лиценз | Уул уурхайн бизнесийн бүтээгдэхүүний лиценз | Сунгалт |
|-------|--|---|-------------------------------|
| Нүүрс | 7 жил | 20 жил | 10 жилээр 2 удаа сунгаж болно |

Мөн энэ хуулиар тухайн уул уурхайн компанийн хувьд бүтээгдэхүүн олборлож эхэлсэнээс хойш 5 дах жилээс эхлэн уул уурхайн компанийн гадаадын хөрөнгө оруулалтын эзэмших хувь хэмжээг хязгаарлах ба уул уурхайн бизнесийн олборлох лицензийн 20-оос дээш хувийг Индонез улсын иргэн эзэмшихээр зохицуулсан байдаг.

Хүснэгт 25. Нүүрс олборлох хүртлэх гэрээний тогтоосон үе шат, хугацаа

| Үе шат | Хугацаа /жил/ | Сунгалт /жил/ |
|-------------------------------|---------------|-------------------------------|
| Ерөнхий судалгаа | 1 | 1 |
| Хайгуул хийх | 3 | 2 /гуравдугаар хугацааны үед/ |
| Техник эдийн засгийн үндэслэл | 1 | 1 /гуравдугаар хугацааны үед/ |
| Барилга байгууламж | 3 | - |
| Бүтээгдэхүүн буюу олборлолт | 30 | - |

5. ОХУ**Ангилал.**

ОХУ-д мөрдөгдөж байгаа нүүрсний ангилал (ГОСТ 25543-88⁵⁰) нь генетик болон технологийн параметраар ангилсан байна. Тус улсын нүүрсний ангилал нь нэлээд дэлгэрэнгүй бөгөөд Хүснэгт 26-д товч байдлаар гол нүүрсний маркуудыг оруулсан байгаа. Дэлгэрэнгүй ангилалд нүүрсний бусад маркууд болон тэдгээрийн дэд ангилалууд болох хэсэг бүрийг нарийн ангилсан байна. Тухайлбал “Б” үсгэн тэмдэглэгээтэй хүрэн нүүрсний марк нь 1Б, 2Б, 3Б гэсэн 3 хэсэгт задран хувагдана. Мөн “Д” тэмдэглэгээтэй урт дөлт нүүрс болон “Г” тэмдэглэгээтэй хийжсэн нүүрсний холимог “ДГ” тэмдэглэгээтэй урт дөлт хийжсэн нүүрсний марк гэх мэдээр ангилсан байна.

Хүснэгт 26. **ОХУ-ын нүүрсний ангилал** (ГОСТ 25543-88)

| Нүүрсний марк | Үсгэн тэмдэглэгээ | Дэгдэмхий бодисын гарц, V, % | Нүүрстөрөгчийн агууламж, C, % | Шаталтын дулаан, Q, ккал/кг | Ойлтын зэрэг, % |
|-------------------|-------------------|------------------------------|-------------------------------|-----------------------------|-----------------|
| Хүрэн | Б | 41 ба түүнээс дээш | 76 ба түүнээс бага | 6900-7500 | 0,30-0,49 |
| Урт дөлт | Д | 39 ба түүнээс дээш | 76 | 7500-8000 | 0,50-0,64 |
| Хийжсэн | Г | 36 | 83 | 7900-8600 | 0,65-0,84 |
| Тослог | Ж | 30 | 86 | 8300-8700 | 0,85-1,14 |
| Коксждог | К | 20 | 88 | 8400-8700 | 1,15-1,74 |
| Гачигданги бөсдөг | ОС | 15 | 89 | 8450-8780 | 1,75-2,04 |
| Гачигданги | Т | 12 | 90 | 7300-8750 | 2,05-2,49 |
| Антрацит | А | 8-аас багагүй | 91 ба түүнээс дээш | 8100-8750 | 2,50-6,00 |

Олборлолт. Өнөөгийн байдлаар ОХУ-ын нүүрсний үйлдвэрлэл нь 100 хувь хувийн хэвшилд хамааралтай. Тус улсын нүүрс олборлолт 2004-2011 оны хооронд 40 хувь өссөн байна. ОХУ-ын Эрчим хүсний яамны мэдэгдэж байгаагаар өнгөрсөн 2011 онд хамгийн их нүүрс олборлосон бөгөөд өмнөх 2010 оныхоос 4 хувиар өссөний үр дүнд салбарын нийт орлого 120 тэрбум рублээр нэмэгдсэн байна.⁵¹

Хүснэгт 27. Нүүрс үзүүлэлтүүд⁵², (2010-2011 он, мянган тонн)

| Үзүүлэлтүүд | 2010 | 2011 |
|-------------|-----------|-----------|
| Олборлолт | 321 093.4 | 334 752.7 |
| Нийлүүлэлт | 295 422.7 | 308 690.5 |


⁵⁰ Russia_gost_25543-88_httpprotect.gost.ru

⁵¹ http://minenergo.gov.ru/activity/coalindustry/state_of_the_industry/

⁵² <http://minenergo.gov.ru/activity/statistic/>

| | | |
|---------|----------|-----------|
| Экспорт | 96 465.5 | 104 655.6 |
|---------|----------|-----------|

Зураг 7. Нүүрсний үзүүлэлтүүд⁵³ (Олборлолт, Нийлүүлэлт, Экспорт)
(2009.12.01-2011.12.30 - ны хооронд, мянган тонн)



Эрчим хүчний яамны боловсруулсан 2030 он хүртэлхи нүүрсний салбарыг хөгжүүлэх урт хугацааны хөтөлбөрийг ОХУ-ын Засгийн газар 2012 оны 1-р сард баталсан байна. Найман дэд хөтөлбөртэй уг хөтөлбөрийг хэрэгжүүлснээр төр, хувийн хэвшлийн түншлэл шинэ түвшинд гарах гэж үзэж байгаа. Мөн тус улсын нийт нүүрс олборлолт 2030 он гэхэд 420 мянган тоннд хүрэх төлөвлөгөөтэй байна.

Экспорт. Тус улсын экспортын татвар нь нүүрсний төрлөөс хамаарч 0-6.5 хувийн татвар ногдуулдаг байна. Тодруулбал, коксжих болон хагас коксжих нүүрсэнд ногдох экспортын татвар 0 хувь, харин хүрэн нүүрсэнд ногдох экспортын татвар 6.5 хувь байна. Эрчим хүчний яамны мэдээнээс харахад 2012 оны эхний 4 сард экспортлосон нийт нүүрсний хэмжээ 39 192.5 мянган тонн байгаа нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 121 хувиар өссөн байна. (Хүснэгт 28)

Хүснэгт 28. Нүүрс үзүүлэлтүүд⁵⁴, (2011-2012 он, мянган тонн)

| Үзүүлэлтүүд | 2012 оны эхний 4 сарын байдлаар | | | 2011 оны эхний 4 сарын байдлаар | | |
|----------------|---------------------------------|----------------------------------|-------|---------------------------------|----------------------------------|-------|
| | Мянган тонн | Өмнөх оны мөн зетэй харьцуулахад | | Мянган тонн | Өмнөх оны мөн зетэй харьцуулахад | |
| | | +/- | % | | +/- | % |
| Нийт олборлолт | 113537.0 | 4942.0 | 104.6 | 108595.0 | 623.8 | 100.6 |

⁵³ <http://minenergo.gov.ru/activity/statistic/>

⁵⁴ <http://minenergo.gov.ru/activity/statistic/>

| | | | | | | |
|-----------------|----------|--------|-------|----------|--------|-------|
| Нийт нийлүүлэлт | 107665.5 | 2192.9 | 102.1 | 105472.6 | 2675.4 | 102.6 |
| Экспорт | 39192.5 | 6775.7 | 120.9 | 32416.8 | 735.4 | 102.3 |

ОХУ -ын Татварын албаны мэдээгээр 2012 оны эхний 3 сарын байдлаар экспортод 466.1 мянган тонн коксжих болон хагас коксжих нүүрс худалдаалж 115.4 сая ам.долларын орлого олсон байна. Харин чулуун нүүрснээс 27,516.4 мянган тонныг худалдаалж 3,039.2 сая ам.долларын орлого олсон нь ОХУ-ын экспортын барааны гол нэрийн барааны хамгийн орлого өндөртэй 10 нэр төрөлд орж байна.

6. ӨМНӨД АФРИКИЙН БҮГД НАЙРАМДАХ УЛС

Өмнөд Африк нь нүүрс олборлолт болон нөөцийн хэмжээгээр АНУ, Хятад, Энэтхэг зэрэг улсуудыг гүйцэхээр том үйлдвэрлэгч орон биш хэдий ч олон улсын нүүрсний зах зээл дээр нэлээн чухал нийлүүлэгч улс юм. Өмнөд Африкийн хувьд нүүрсний салбарт: **нэгд**, бага үнэ өртгөөр нүүрсний үйлдвэрлэл явуулдаг, **хоёрт**, экспортод гаргах томоохон хэмжээний боомттой, Атлантын болон Номхон далайн голд байрласан нүүрсний зах зээлтэй зэрэг хэд хэдэн давуу талтай улс юм. Гол экспортлодог улсууд нь:

- Европын орнуудаас - Бельги, Дани, Франц, Герман, Итали, Португаль, Испани
- Азийн орнуудаас - Энэтхэг, Хятад, Өмнөд Солонгос, Малайз, Пакистан, Тайвань,
- Ойрхи дорнодын орнуудаас - Израйл, Турк, Арабын Нэгдсэн Эмират Улс,
- Африкийн орнуудаас - Марокко, Кени, Сенегал
- Латин Америкийн орнуудаас - Аргентин, Бразил, Чили, Мексик зэрэг улсууд руу нүүрсээ экспортолж байна.

Өмнөд Африк нь 2011 оны байдлаар нүүрсний олборлолтоороо дэлхийд Хятад, АНУ, Индонез, Австрали, Энэтхэг улсуудын дараа 6-д, харин нүүрсний экспортоороо Индонез, Австрали, Орос улсын дараа ордог байна. Тус улсын хувьд 2009 онд 247 сая тонн нүүрс олборлосон бөгөөд үүний 27% буюу 67 сая тонн нүүрс экспортолсон бөгөөд уг экспортолсон нүүрсний 99%-ийг эрчим хүчний нүүрс эзэлсэн байна.

2010 оны 9 сард тус улсын хувьд нүүрсний экспортын дийлэнхийг Ази болон Европын орнууд руу экспортолсон бөгөөд 2010 эхний 8 сарын байдлаар Азийн орнууд руу 29 сая тонн, Европ руу 5.8 сая тонныг ачуулсан байна. 2011 оны 10 сард 7.4 сая тонн нүүрс экспортолсон бөгөөд сүүлийн 3 жилийн хугацаанд сард дунджаар 4-5 сая тонн нүүрс экспортолж байна. Тус улсын ихэнх экспортын үйл ажиллагааг Anglo American /34%/, BHP Billiton /31%/, Xstrata /20%/ гэсэн томоохон корпорациуд бусад компаниудын хувьд нүүрсний экспортын 14%-ийг гүйцэтгэдэг байна. Richards Bay боомт нь дэлхийн хамгийн том нүүрсний экспортын боомт юм. Мөн экспортыг хариуцдаг гол байгууллагууд нь Anglo American BHP-Billiton Xstrata болон бусад /14%/ гэж байдаг.

Хүснэгт 29. Экспортын нүүрсний төрөл, үнэ, хэмжээ

| Бүтээгдэхүүн | Олборлолтын хэмжээ /сая тонн/ | Дотоод | | | Экспорт | | |
|------------------|-------------------------------|------------------------|------------|-----------------|------------------------|------------|------------------|
| | | Хэмжээ /сая тонн/ /Mt/ | Чанар /Rm/ | Үнэ /рэнд/ /Rt/ | Хэмжээ /сая тонн/ /Mt/ | Чанар /Rm/ | Үнэ /рэнд*/ /Rt/ |
| Нүүрс | 249.7 | 171.1 | 29 606 | 173 | 61.1 | 31 118 | 509 |
| Антрацит /бүхэл/ | 1.6 | 0.7 | 498 | 710 | 0.4 | 368 | 836 |

| | | | | | | | |
|--------------------------------------|-------|-------|--------|-----|------|--------|-----|
| Битумтай тослог нүүрс /бүхэл/ | 248.1 | 170.4 | 29 108 | 171 | 60.7 | 30 712 | 506 |
| Битумтай тослог нүүрс /эрчим хүчний/ | 247.7 | 168.6 | 29 482 | 163 | 60.5 | 30 465 | 504 |
| Битумтай тослог нүүрс /коксжих/ | 0.4 | 1.8 | 1625 | 871 | | | |

*-1 рэнд = 0.12005 ам.долл

2007 оны байдлаар нэг тонн нүүрсний үнэ 27 - 48 америк доллар байсан бөгөөд энэ үнийн 2/3 -ийг анхан шатны боловсруулалтын зардал, j дахин боловсруулах зардал, боомтын татварт 10% эзэлдэг байна. 2008 оны 6 сард 60 америк доллар/тонн болж өссөн боловч 10 сараас дэлхийн эдийн засгийн хямрал эхэлсэнтэй холбоотойгоор нэг тонн нүүрсний үнэ 8 ам.долл болж буурсанаас хойш өнөөгийн байдлаар 10-20 ам.долл байна.

Өмнөд Африкийн нүүрсний экспортын татварын хувьд тодорхой мэдээлэл олдоогүй бөгөөд харин нүүрсэнд ногдох нийт татварын хувьд дараах байдлаар ногдуулдаг байна.

- Компанийн татвар: 28% (дэлхийн орлогын горим). Хэвийн татвар дээр компаниуд хоёр дахь татвар (КХТ) (Secondary Tax on Companies - STC) нэмж төлөх ёстой. Өөрөөр хэлбэл энэ нь жилийн ноогдол ашгийн 10% юм. Нийт татвар нь хэвийн татвар болон КХТ-ийн нийлбэрээс бүрдэх бөгөөд энэ нь зарласан ноогдол ашгийн хэмжээнээс хамааран өөрчлөгддөг. Хөрөнгийн ашгийн орлогын татварын хэмжээ нь 14% байна.
- Мөнгөн шилжүүлгийн татвар: Ноогдол ашигт 0% - Өмнөд Африк одоогоор ноогдол ашгаас татвар авахгүй байгаа. Гэсэн хэдий ч 10%-ийн татвар авах төлөвлөгөөтэй байгаа. Энэ нь гэрээний дагуу авах ёстой татвар.
- Лиценз (уурхайг ашигласны)-ийн төлбөр 12% - Орлогын татварын акт нь 12%-ийн татварыг лиценз (уурхайг ашигласны)-ийн төлбөрөөс хасаж тооцох боломжтой.
- Өмнөд Африк нь давхар татварын хэлэлцээр оршин суугч бус этгээдийн оршин суудаг улстай хийдэг. Үүнийг гэрээний дагуу 0%, 5% эсвэл 10% болгон багасган тооцох боломжтой.
- Оршин суугч бус этгээд үл хөдлөх хөрөнгө ашигласны төлбөр 7.5%,
- Байнгын оршин суугч бус этгээд 15%.
- Уул уурхайн тусгай татвар: 28%-ийн корпорацын стандарт татвар ба 10%-ийн КХТ нь уурхайн компаниудад ноогддог. Түгээсэн ашгийн нийт идэвхтэй хэвийн татварын хэмжээ нь 36,89%.

Алт олборлогч компанийн хувьд аль нэг татварыг төлөхөөр сонгож болох бөгөөд эсхүл КХТ-г төлөхгүй байж болно. Хэрэв компанийн хувьд КХТ-г төлөхөөр сонговол алтны олборлолт татвар төлөх ёстой гэсэн татварын хэмжээг тооцоолох аргачлалын дагуу бодогдоно. Үүнд дээр нэмээд уул уурхайн компаниуд нь НӨАТ, гаалийн татвар, акцын татвар (онцгой албан татвар) ба ур чадварыг хөгжүүлэх хураамж заавал төлөх үүрэгтэй байна. Уурхайг ашигласны татвар нь цэвэршүүлсэн эсвэл цэвэршүүлээгүй аль аль ашигт малтмалд тооцогддог. Сонирхолын татвар болох 10%-ийн татвар нь 2013 оноос хэрэгжиж эхэлнэ.

| № | Төрөл | Хувь хэмжээ |
|---|--|---|
| 1 | НӨАТ | 14% |
| 2 | Аж ахуйн нэгжийн орлогын албан татвар | 28% |
| 3 | Хувь хүний орлогын албан татвар | 18-40% |
| 4 | Аж ахуйн нэгжийн 2 дахь татвар | 10% /Компанийн жилийн ноогдол ашгийн 10 хувь/ |
| 5 | Нөөц ашигласны татвар /роялти/ | 12% |
| 6 | Онцгой албан татвар | 5-10% |
| 7 | Газрын төлбөр | 20% |
| 8 | Түгээсэн ашгийн нийт идэвхтэй хэвийн татварын хэмжээ | 36.89% |
| 9 | Бусад, үүнд: Оршин суугч бус этгээд үл хөдлөх хөрөнгө ашигласны төлбөр, Байнгын оршин суугч бус этгээд, Шатахууны хураамж, ур чадвар дээшлүүлэх хураам гэх мэт | 7.5% - 15%, Бензин 29.6% Дизель 30.3% |
| | | Ойролцоогоор 57% |

Өмнөд Африкийн Бүгд Найрамдах улсын 2010 - 2011 оны улсын төсвийн татварын орлого нь: хувь хүний орлогын албан татвар 33.66%, нэмэгдсэн өтгийн албан татвар 27.32%, аж ахуйн нэгжийн орлогын албан татвар 19.79%, шатахууны татвар 5.2%, бусад татвар 4.39%, гаалийн татвар 3.94%, онцгой албан татвар 3.18%, аж ахуйн нэгжийн 2 дахь албан татвар 2.52%.

Татварын хөнгөлөлт

Уул уурхайн компани нь нийт хөрөнгийн зардлын урьдчилгаа мөнгийг авах эрхтэй байх бөгөөд үйлдвэрлэлийн шатанд буюу олборлолтын үед уул уурхайн бүтээгдэхүүн ашиглалтын татвар төлөх бүрэн хэмжээнд хүрсэн тохиолдолд урьдчилгаа мөнгө хүсэх боломжтой.

7. ХЯТАД УЛС

Нүүрс нь дэлхийн нийт энергийн эх үүсвэрийн 37 орчим хувийг дангаараа эзлэн тэргүүлдэг бөгөөд үүний дараа газрын тос ордог байна. Харин Хятад улсад нүүрс нь хамгийн давамгай байдалтай ашиглагддаг энергийн эх үүсвэр юм. Тухайлбал, тус улсын нийт муж нутгийн 70 орчим хувьд нүүрсийг голчлон ашигладаг буюу тухайн бүс нутгууд нийт эрчим хүчнийхээ 93 хувийг нүүрснээс гарган авдаг байна.

2010 оны байдлаар тус улс нь 3,24 тэрбум тонн нүүрс олборлосон нь дэлхий даяар олборлосон нүүрсний бараг тэн хагастай нь тэнцэхүйц хэмжээтэй байна. Үүний зэрэгцээ Хятад улс нь нүүрсний томоохон импортлогч орны тоонд ордог бөгөөд энэ их хэмжээний нүүрснээс гарган авсан эрчим хүчийг эдийн засгийн өсөлт хөгжилтийн гол түлхүүр болсон хүнд аж үйлдвэрүүдээ хангахад чиглүүлдэг. Гэхдээ нийт олборлосон нүүрсээ бүгдийг нь дотооддоо хэрэглэдэггүй, нэлээд хэсгийг нь гадагшаа экспортлодог ба экспортын хэмжээгээр дэлхийд эхний 5-д багтдаг. Урд нь тус улс цэвэр нүүрс экспортлогч улс байсан бөгөөд үүнд нүүрсний асар их нөөц, хямд ажиллах хүч, экспортын таатай үнэ, Засгийн газраас үзүүлэх татварын хөнгөлөлт зэрэг нь гол нөлөө үзүүлдэг байсан.

2003 онд Хятадын нүүрсний экспорт оргилдоо хүрч байсан бөгөөд энэ үед 94 сая тонн нүүрс экспортлосон байна. Үүнээс хойш дотоодын нүүрсний хэрэгцээний хомсдлоос үүдэн Засгийн газраас нүүрсний экспортыг хязгаарлах бодлого барьж эхэлснээр нүүрсний экспорт жил бүр буурах болсон. 2009 онд Хятадын нүүрс олборлогч голлох компаниуд болон эрчим хүч үйлдвэрлэгч компаниудын хооронд болсон эрчим хүчний нүүрсний үнийн талаарх сунжирсан маргаан хэлэлцүүлгийн үр дүнд тус улс олон улсын зах зээл дээрээс хамгийн таатай үнэ бүхий нүүрсийг дотооддоо импортлох болсон.

Олон улсын нүүрсний худалдаанд далайн тээвэр гол үүргийг гүйцэтгэдэг буюу 2009 оны байдлаар нүүрсний экспортын нийт тээвэрлэлтийн 91 хувийг далайн тээврээр гүйцэтгэсэн байна. Тэгвэл Хятад улс энэхүү далайн тээвэрт 1/3 -ээс багагүй хувийг эзлэдэг ба нүүрсний экспорт импортын хэмжээгээр дээгүүрт ордог тул нүүрсний дэлхийн зах зээл дээр гол тоглогчдын нэг болж чаддаг.

БНХАУ-ын нүүрс олборлох, ашиглах, борлуулахтай холбоотой эрх зүйн зохицуулалт

БНХАУ-ын ашигт малтмал тэр дундаа нүүрс ашиглахтай холбоотой аливаа харилцааг дараахь хууль болон эрх зүйн бусад актуудаар зохицуулдаг байна.

Хүснэгт 30. Нүүрс үйлдвэрлэлд холбогдох эрх зүйн баримт бичгүүд

| Type of policy | Title |
|-------------------------------------|---|
| Laws and Regulations | Environmental Protection Law |
| | Atmospheric Pollution Prevention and Control Law |
| | Solid Waste Pollution Prevention and Control Law |
| | Environmental Impact Assessment Law |
| | Energy Conservation Law |
| | Circular Economy Promotion Law |
| | Cleaner Production Promotion Law |
| | Coal Law |
| | Mineral Resources Law |
| | Water and Soil Conservation Law |
| | Land Administration Law |
| Administrative Orders and Standards | Decisions of the State Council on Implementing the Scientific Development Concept to Strengthen Environmental Protection |
| | Opinions of the State Council on Promoting the Sound Development of the Coal Industry |
| | Special Regulation on Land Reclamation, Provisional Measures for Environmental Protection in the Coal Industry, Emission Standard for Pollutants from the Coal Industry |
| | Cleaner Production Standard for the Coal Industry, Emission Standard of Coal Bed Methane/Coal Mine Gas |
| | Guideline of Environmental Impact Assessment for Coal Mining Projects |

| | |
|------------------------------------|---|
| Other Relevant Government Policies | 11th Five Year Plan on the Prevention of Acid Rain and Sulphur Dioxide Pollution |
| | 11th Five Year Plan on the Development of the Coal Industry, Coal Industry Policy |
| | Opinions (of the NDRC) on Emission Reductions and Energy Conservation in the Coal Industry |
| | Opinions (of the NDRC) on Coal Mine Methane Control and Utilization, Technical Policies for Sulphur Dioxide Emission Prevention and Control |
| | Opinions of the NDRC on the Experiment of Sustainable Development in the Coal Industry in Shanxi |
| | 9th Five Year Plan on Cleaner Coal Technology and Development Outline in 2010 |
| | Preferential Policy on Power Generation Demonstration Projects with Cleaner Coal Technologies |

Source: TFSUC (2009).

Үүнээс:

- Ашигт малтмал ба эрдэс баялгийн тухай хууль /Mineral resources law/ нь ерөнхийдөө БНХАУ-ын ашигт малтмалын салбарын хөгжил, ашигт малтмалын хайгуул, илрүүлэлт, ашиглалт болон хамгаалалтын талаарх эрх зүйн харилцааг зохицуулсан гол хууль юм.
- Нүүрсний тухай хууль /Coal law/ нь БНХАУ-ын нүүрсний салбарыг хөгжүүлэх, нүүрсний нөөцийг зохистойгоор ашиглах, хамгаалах, нүүрснээс гаргаж авах бүтээгдэхүүнүүдийг стандартжуулах, борлуулах зэрэг харилцааг зохицуулна.

Тус хууль нь найман бүлэгтэй:

1. Нийтлэг үндэслэл
2. Нүүрсний үйлдвэрлэл хөгжил ба нүүрсний уурхай байгуулах төлөвлөгөө
3. Нүүрсний үйлдвэрлэл ба нүүрсний уурхайн аюулгүй ажиллагаа
4. Нүүрсний борлуулалт
5. Нүүрсний орд газрын хамгаалал
6. Хяналт шалгалт
7. Хуулийн хариуцлага
8. Нэмэлт зохицуулалтууд

Нэгдүгээр бүлэгт зааснаар нүүрсний орд газрууд нь улсын өмч байх ба орд газрын байрлаж буй газар хэний өмч байхаас үл хамааран газрын гадарга болон хэвлий дэх нүүрсний нөөц нь улсын өмчид тооцогдоно. Мөн засгийн газар нь нүүрсийг олборлох ашиглах талаар нэгдсэн төлөвлөгөө боловсруулах, нүүрсний нөөцийг хамгаалах, нүүрсний салбарт хөрөнгө оруулагчдын эрх ашгийг хамгаалах, нүүрсний уурхайн аюулгүй ажиллагааг хангах үүднээс бодлого боловсруулах, нүүрс олборлож буй этгээд нь байгаль орчны хууль зохицуулалтуудын дагуу ажиллах үүрэгтэй.

Хоёрдугаар бүлэг буюу Нүүрсний үйлдвэрлэл, хөгжил ба нүүрсний уурхай байгуулах төлөвлөгөөний тухай зохицуулсан энэхүү бүлэгт зааснаар БНХАУ-ын Улсын хорооны харъяанд ажилладаг Нүүрсний бодлого зохицуулах хэлтэс нь нүүрсний хайгуул, илрүүлэлтийг төлөвлөгөөний дагуу гүйцэтгэх үүрэгтэй. Түүнчлэн нүүрсний уурхай байгуулахад шаардагдах шаардлагууд юу болох, уурхай байгуулах хүсэлтүүдийг хэрхэн хянаж шийдвэрлэх, олборлолтын зөвшөөрөл хэрхэн яаж олгох, уурхай барих төлөвлөгөөг байгаль орчинд ээлтэй хэлбэрээр боловсруулах гэх зэрэг асуудлыг зохицуулсан байна.

Гуравдугаар бүлэг буюу Нүүрсний үйлдвэрлэл, нүүрсний уурхайн аюулгүй ажиллагаа гэсэн хэсэгт Нүүрсний олборлолт явуулах зөвшөөрөл бүхий уурхайнууд нүүрсний үйлдвэрлэл явуулахын тулд Нүүрсний аж үйлдвэрийн асуудал эрхлэх хэлтсээс үйлдвэрлэлийн зөвшөөрөл авах ёстой бөгөөд зөвшөөрөл олгохдоо нүүрсний үйлдвэрлэл, үйлдвэрлэлийн аюулгүй байдал зэргийг тус хэлтэст шалгуулна гэж заасан байна.

Нүүрсний үйлдвэрлэлийн зөвшөөрөл авахын тулд хүчин төгөлдөр нүүрс олборлох зөвшөөрөлтэй байх, нүүрсний үйлдвэрлэлийг аюулгүй явуулах техник технологи, машин төхөөрөмжтэй байх, хуулийн дагуу нүүрсний үйлдвэрлэлийн чиглэлээр боловсрол эзэмшсэн инженер, боловсон хүчин, шаардлага хангасан мэргэжлийн ажилчид, газрын гадарга болон уурхайн гүнийг холбосон техникийн шаардлага хангасан холбооны системийг нэвтрүүлсэн байх, газрын гүний агааржуулалтын систем, ухалтын төлөвлөгөө зэрэг нь шаардлага хангасан байх, нүүрсний олборлолт болон үйлдвэрлэлийн тоног төхөөрөмж технологи нь байгаль орчинд аюулгүй байх зэрэг үндсэн шаардлагыг хангасан байх ёстой гэж заажээ.

Дөрөвдүгээр бүлэг буюу Нүүрсний борлуулалтын талаархи эрх зүйн зохицуулалт нь нүүрсний борлуулалт, худалдааны зөвшөөрөл авах асуудал, нүүрсний худалдаа хийх компани аж ахуйн нэгжээс шаардагдах шаардлагууд, тэдний үүрэг хариуцлага, нүүрсний үнийн зохицуулалт, нүүрсний чанарт тавих шаардлагууд, нүүрсний чанар шаардлага хангаагүй асуудлыг хэрхэн зохицуулах, нүүрс, нүүрсэн бүтээгдэхүүнийг хэрхэн хэмжих зэрэг асуудлуудыг зохицуулсан байна.

Тавдугаар бүлэг буюу Нүүрсний орд газрын хамгаалалын тухай бүлэгт зааснаар нүүрсний олборлолт нь үйлдвэрлэлийн газруудын харилцаа холбоо, эрчим хүч, усан хангамж зэрэгт хохирол үзүүлэхийг хориглосон талаархи зохицуулалтууд орсон байна. Мөн тус бүлэгт заасны дагуу нүүрсний уурхайн зөвшөөрөлгүйгээр уурхайн эзэмшлийн газар нутаг дээр мал маллах, тариа ногоо тарих, барилга байгууламж барих, төмөр зам, зам тавих, цахилгааны шугам татах, усан хангамжийн хоолой зэргийг суулгах нь хориотой тухай зохицуулсан байна.

Зургадугаар бүлэг буюу Хяналт шалгалтын хэсэгт заасан нүүрсний уурхайн үйл ажиллагааг Нүүрсний бодлого зохицуулах хэлтэс хянан шалгах үүрэгтэй бөгөөд тус хэлтэсийн хянан шалгах эрхийг хуульчилан тогтоосон байна.

Нүүрсний ангилал

Хятадын нүүрсний нөөц бүхий нийт талбайн хэмжээ 600,000 км² байдаг нь тус улсын 9,6 сая км² газар нутгийн 6 хувийг эзлэдэг гэсэн үг юм. Энэхүү нүүрсний нөөц бүхий газар нутгийг таван үндсэн дүүрэгт хуваадаг.

1. Зүүн хойд
2. Хойд Хятад
3. Өмнөд хятад
4. Баруун хойд
5. Түвд
6. Юннан гэж хуваана.

Уул уурхайн яамны 2006 оны тайланд дурьдснаар нийт 7965 уурхайд ойролцоогоор 1160 их наяд тонн (Gt) нүүрс байгаа гэж тооцсон бөгөөд үүний 334 их наяд тонн нь байгаа нөөц, 826 их наяд тонн нь таамаг нөөц гэж дурджээ. Энэхүү нүүрсний уурхайн бүс нутгууд дахь нөөцийн хэмжээг уурхай тус бүрээр дараах хүснэгтэд харуулъя.




Хүснэгт 30. Нүүрсний нөөцийн хэмжээ их наяд тонноор (Gt)

| Бүс нутгууд | Уурхайн тоо | Батлагдсан нөөц | Байгаа нөөц | Таамаг нөөц | Нийт нөөц |
|--|-------------|-----------------|-------------|-------------|-----------|
| Jing-Jin-Ji (Beijing, Tianjin, Hebei) | 277 | 2.7 | 7.69 | 9.57 | 17.25 |
| Northeast (Liaoning, Jilin, Heilongjiang) | 1208 | 5.45 | 14.45 | 17.57 | 32.03 |
| East China (Jiangsu, Zhejiang, Anhui, Fujian, Jiangxi, Shandong) | 1440 | 11.01 | 25.38 | 31.17 | 56.54 |
| Central South + Hainan (Henan, Hubei, Hunan, Guangdong, Guangxi, Hainan) | 1576 | 8.37 | 15.79 | 17.12 | 32.91 |
| Jin-Shang-Meng-Ning (Shanxi, Shaanxi, Inner Mongolia, Ningxia) | 1320 | 126.51 | 220.16 | 532.15 | 752.31 |
| Southwest (Chongqing, Sichuan, Guizhou, Yunnan) | 1454 | 18.25 | 29.04 | 62.93 | 91.96 |
| Xin-Gan-Qing + Tibet (Gansu, Qinghai, Xinjiang, Tibet) | 690 | 10.25 | 20.98 | 155.80 | 176.77 |
| Нийт нүүрс | 7965 | 182.54 | 333.48 | 826.30 | 1159.78 |
| Коксжих нүүрс | | 64.3 | 124.2 | 150.3 | 274.8 |

Эх сурвалж: Huang et al. (2008) and CCTD

Нийт нүүрсний нөөцийн хэмжээ нь ийнхүү байгаа бөгөөд үүнийг төрлөөр нь ангилсныг дараачийн зурагт харуулъя.

Зураг 8. Нүүрсний ангилал




Зургаас харахад лигнит буюу хүрэн нүүрс нийт нөөцийн 13.5 хувийг эзэлж байна. Тэгвэл энэхүү хүрэн нүүрсний нөөцийн дийлэнх буюу 76.5 хувь нь Өвөрмонголд байдаг бол 13.8 хувь нь Юннанд байдаг байна.

Хүснэгт 31. БНХАУ -ын нүүрсний ангилал (ГОСТ 25543-88)

| | | | | | | | |
|------------------|--------------------------|---------------|---------------------------------------|------------------------|--|---|---------------------|
| Бөхөс индекс (G) | >85 | Антрацит (WY) | Тослог нүүрс (FM) (Y<25mm) | | | Хийн тослог нүүрс (GF) (Y<25mm, b<220) | |
| | 65-85 | | Коксжих нүүрс (JM) (Y<25mm, b<150) | | 1/3 коксжих нүүрс (1/3 JM) (Y<25mm, b<220) | Хийн нүүрс (QM) (Y<25mm, b<150) | |
| | 50-65 | | Туранхай нүүрс (SM) | S коксжих нүүрс (S JM) | | | Урт дөлт нүүрс (CY) |
| | 35-50 | | | | | | |
| | 30-35 | | | Сул коксжих нүүрс (RN) | | | |
| | 20-30 | | | | | | |
| | 5-20 | | Тарчиг-туранхай нүүрс (PS) | Коксждоггүй нүүрс (BN) | | | |
| | 0-5 | | Тарчиг нүүрс (PM) | | | | |
| | 0 | | 0 – 10 | 10 – 20 | 20 – 28 | 28 – 37 | > 37 |
| | Дэгдэмхий чанар (daf, %) | | | | | | |

Хагас битумжсан нүүрсний нөөц үндсэндээ Erdos, Datong, өмнөд Liaoning, Xinjiang –д байна. Харин кокжсон нүүрсний нөөц Shanxi, Hebei, Shandong, хойд Jiangsu, хойд Anhui, Heilongjiang, Liaoning, Xinjiang, Guizhou, Sichuan, Hunan, Jiangxi-д байна. Үүнээс 55 хувь нь зөвхөн Shanxi-д байдаг байна. Антрацитыг ихэнхдээ ХАА-н бордоо болон химийн аж үйлдвэрт ашигладаг. 2009 оноос эхлэн антрацитын хэрэглээ нэмэгдэж нийт нүүрс олборлолтын 18,5 хувийг эзэлж эхэлсэн. Лигнитийг голчлон цахилгаан эрчим хүч үйлдвэрлэх болон нүүрс хийжүүлэх ажиллагаанд хэрэглэж байна. Лигнит олборлолтын хэмжээ жил бүр дунджаар 2,7 хувиар буурсаар, одоо 2009 оны үзүүлэлтийг 1990 онтой харьцуулахад 12,3 хувиар буурсан. Битумжсан болон хагас битумжсан нүүрс олборлолт нийт нүүрс олборлолтод гол байр суурь эзэлж байгаа бөгөөд 2009 оны байдлаар нийт нүүрс олборлолтын 69,2 хувийг эзэлж байна. Доорх Зурагт 1952 оноос эхлэн 2009 он хүртэлх Хятад улсын нүүрс олборлолтын хэмжээг төрлөөр нь ангилан харуулав.

Зураг 9.



Эх сурвалж: CNCA (2006), CCII (various years) and industrial sources

Судалгааны эмхтгэл, XIII боть

Эдгээр нөөцийг төрлөөр нь ангилахаас гадна экспортын болон импортын чиглэлээр хувааж бүснутаар нь ангилсан байна.

Хүснэгт 32. Экспортын нүүрсний бүс нутгууд

| Planning Zone | Coal Base | Province | Acreage (Km2) / Reserves (Gt) | List of Mining Districts (No. of Mining District) | Major Rail Lines |
|--------------------|----------------------|---------------------------|-------------------------------|---|---|
| Coal Export Zone | Shendong | Inner Mongolia, Shaanxi | 9,000 / 146.6 | Shendong, Wanli, Zhungeer, Baotou, Wuhai, Fugu (6) | Shen-Shuo-Huang Line, Long-Hai Line |
| | Shaanbei | Shaanxi | 14,440 / 109.8 | Yunshen, Yuheng (2) | Zhengzhou-Xi'an Section of Long-Hai Line, Hou-Xi Line, Xi'an-Nanjing Line, Xi-Kang Line |
| | Huanglong | Gansu | 3,262 / 15.7 | Shanchang (inc. Yonglong), Huangling, Xunyao, Tongchuan, Pubai, Chenghe, Hancheng, Huating (8) | Ning-Xi Line |
| | Jinbei | Shanxi | 5,278 / 58.0 | Datong, Pingshuo, Shuonan, Xuangang, Hebaopian, Lanxian (6) | Da-Qin Line, Feng-Sha-Da Line, Ji-Tong Line |
| | Jinzhong | Shanxi | 8,372 / 917 | Xishan, Dongshan, Fenxi, Huozhou, Liliu, Xiangning, Huodong, Shixi (8) | Shi-Tai Line, Tai-Jiao Line |
| | Jindong | Shanxi | 8,209 / 76.7 | Jincheng, Lu'an, Yangquan, Wuxia (4) | Hang-Chang Line, Tai-Jiao Line |
| | Mengdong (Northeast) | Inner Mongolia, Northeast | 11,723 / 68.4 | Zalainuoer, Baorixile, Yimin, Dayan, Huolinhe, Pingzhuang, Baiyinhua, Shengli, Fuxin, Tiefs, Shenyang, Fushun, Jixi, Qitaihe, Shuangyashan, Hegang (16) | Bin-Sui Line, Sui-Jia Line |
| | Ningdong | Ningxia | 1,100 / 8.8 | Shizuishan, Shitanjing, Lingwu, Yuanyanghu, Hengcheng, Weizhou, Majiatan, Jijiajing, Mengcheng (9) | Ning-Xi Line |
| Coal Import Zone | Lianghuai | Anhui | 6,863 / 27.1 | Huainan, Huaibei (2) | Jing-Hu Line, Huai-Nan Line |
| | Luxi | Shandong | 4,500 / 18.6 | Yanzhou, Jining, xinwen, Zaozeng, Longkou, Zibo, Feicheng, Juye, Huanghebei (9) | Jing-Hu Line, Yan-Shi Line |
| | Henan | Henan | 7,794 / 19.4 | Hebi, Jiaozuo, Yima, Zhengzhou, Pingdingshan, Yongxia (6) | Zhengzhou-Guangzhou Section of Jing-Guang Line, Luoyang-Shimen Section of Jiao-Liu Line |
| | Jizhong | Hebei | 2,556 / 6.5 | Fengfeng, Handan, Xingtai, Jingxing, Kailuan, Yuxian, Xuanhuaxiahuayuan, North Xiangjiakou, Pingyuan Large Coal Fields (9) | Shijiazhuang-Guangzhou Section of Jing-Guang Line |
| Self-Reliance Zone | Yungui | Yunnan, Guizhou | 20,191 / 43.5 | Panxian, Puxing, Shuicheng, Liuzhi, Zhina, Qianbei, Laochang, Xiaolongtan, Zhaotong, Zhenxiong, Enhong, Junlian, Guxu (13) | Nan-Kun Line, Zhu-Liu Line, Qian-Gui Line |

Эх сурвалж: Acreage and resources are based on Wu and Wang (2006) and <http://www.chinacoal.org.cn/coaljyx/266/18786.aspx> [2011-02-11]

Дараагийн хүснэгтүүдэд экспортын хэмжээ, үнэ, экспортлогч компаниудын талаар орууллаа. Эдгээр мэдээллүүд нь 2011 оны 1-р сарын байдлаар байгаа бөгөөд тоон үзүүлэлтүүд сар болгон эсвэл 7 хоног бүрээр шинэчлэгдэж байдаг. Шинэчлэгдсэн сүүлийн үеийн мэдээллийг олж авах нь бизнес агуулгатай байдаг тул эдгээр тоон мэдээллүүд зохих төлбөр бүхий сайтад байршдаг. Иймээс бидний хувьд энэхүү тоон мэдээллүүдийг олж авах, ашиглах бололцоогүй тул нүүрсний экспортын талаар гарсан жилийн тайланг ашигласан болно. Харин АМГ-ын Нүүрс, судалгааны хэлтсээс ирүүлсэн Хятадын дотоодын зах зээл дээрх нүүрсний үнийн сүүлийн тоон мэдээллийг хавсралт болгон оруулав.

Хүснэгт 33. Кокжсон нүүрсний экспортын үнэ (US\$/t FOB)

| | Dec-09 | Jan-10 | Feb-10 | Mar-10 | Apr-10 | May-10 | Jun-10 | Jul-10 | Aug-10 | Sep-10 | Oct-10 | Nov-10 |
|-----------------------------|--------|--------|--------|--------|--------|--------|--------|--------|--------|--------|--------|--------|
| China 12 - 12.5% ash | 395.00 | 395.00 | 417.90 | 435.00 | 459.00 | 498.50 | 480.50 | 392.00 | 441.00 | 434.50 | 438.50 | 465.00 |
| China 10.5% ash | 410.50 | 453.00 | 425.00 | 440.00 | 474.00 | 515.00 | 497.00 | 406.00 | 458.00 | 446.50 | 449.00 | 479.50 |
| Japan 12% ash | 326.50 | 379.00 | 344.00 | 369.00 | 404.00 | 455.50 | 431.00 | 336.00 | 390.00 | 367.50 | 373.00 | 396.00 |
| AV China coke export prices | 385.13 | 412.68 | 414.58 | 452.58 | 394.57 | 406.14 | 418.86 | 453.48 | 403.23 | 396.38 | 384.54 | 401.72 |
| China Coke Exports (kt) | 60 | 40 | 50 | 40 | 240 | 470 | 560 | 590 | 210 | 230 | 220 | 360 |

Эх сурвалж: Chinese Customs/Energy Publishing/Coal Americas

Хүснэгт 34. Нүүрс экспортлогч компаниудын экспортлосон нүүрсний хэмжээ (мянган тонноор)

| | Oct 09 | Nov 09 | Dec 09 | YTD 09 | Jan 10 | Feb 10 | Mar 10 | Apr 10 | May 10 | Jun 10 | Jul 10 | Aug 10 | Sep 10 | Oct 10 | YTD 10 |
|------------|--------|--------|--------|--------|--------|--------|--------|--------|--------|--------|--------|--------|--------|--------|--------|
| China Coal | 0.2 | 0.5 | 0.5 | 3.1 | 0.4 | 0.4 | 0.5 | 0.4 | 0.8 | 0.3 | 0.4 | 0.2 | 0.4 | 0.1 | 3.9 |
| Shenhua | 1.2 | 1.2 | 1.3 | 9.9 | 1.2 | 1.1 | 1.6 | 0.6 | 0.6 | 0.7 | 0.8 | 0.9 | 0.8 | 0.6 | 8.9 |
| TOTAL | 1.4 | 1.7 | 1.8 | 13.0 | 1.6 | 1.5 | 2.1 | 1.0 | 1.4 | 1.0 | 1.2 | 1.1 | 1.2 | 0.7 | 12.8 |

Эх сурвалж: Chinese Customs Authorities

Эх сурвалж: Chinese Customs Authorities

Хүснэгт 35. Экспортын нүүрсний төрлүүд болон кокжсон нүүрсний экспорт (мянган тонноор)

| | Dec-09 | Jan-10 | Feb-10 | Mar-10 | Apr-10 | May-10 | Jun-10 | Jul-10 | Aug-10 | Sep-10 | Oct-10 | Nov-10 |
|-----------------------------|--------|--------|--------|--------|--------|--------|--------|--------|--------|--------|--------|--------|
| China 12 - 12.5% ash | 395.00 | 395.00 | 417.90 | 435.00 | 459.00 | 498.50 | 480.50 | 392.00 | 441.00 | 434.50 | 438.50 | 465.00 |
| China 10.5% ash | 410.50 | 453.00 | 425.00 | 440.00 | 474.00 | 515.00 | 497.00 | 406.00 | 458.00 | 446.50 | 449.00 | 479.50 |
| Japan 12% ash | 326.50 | 379.00 | 344.00 | 369.00 | 404.00 | 455.50 | 431.00 | 336.00 | 390.00 | 367.50 | 373.00 | 396.00 |
| AV China coke export prices | 385.13 | 412.68 | 414.58 | 452.58 | 394.57 | 406.14 | 418.86 | 453.48 | 403.23 | 396.38 | 384.54 | 401.72 |
| China Coke Exports (kt) | 60 | 40 | 50 | 40 | 240 | 470 | 560 | 590 | 210 | 230 | 220 | 360 |

Эх сурвалж: Chinese Customs Authorities

Хүснэгт 36. Экспортод гаргаж буй нүүрсний ангилал, хэмжээ (мянган тонноор)

| Exports | Nov 10 | Nov 09 | YOY/M | YTD Nov 10 | YTD Nov 09 | YOY/Total |
|--------------------|---------------|---------------|--------------|-------------------|-------------------|------------------|
| Grand Total | 1,280 | 1,429 | -10% | 11,421 | 13,083 | -13% |
| | | | | | | |
| Anthracite | Nov 10 | Nov 09 | YOY/M | YTD Nov 10 | YTD Nov 09 | YOY/Total |
| Total | 387 | 215 | 80% | 3,878 | 2,770 | 40% |
| Korea(DPRK) | | | | 7 | 2 | 274% |
| Indonesia | | | | 3 | 12 | -74% |
| Japan | 89 | 102 | -13% | 1,601 | 1,125 | 42% |
| Malaysia | 6 | | | 12 | 12 | 4% |
| Taiwan | 14 | | | 84 | 1 | |
| Philippines | | | | 2 | 7 | -75% |
| South Korea | 277 | 111 | 149% | 2,135 | 1,569 | 36% |
| Europe | | | | 28 | 10 | 175% |
| Other | 1 | 2 | -47% | 6 | 33 | -82% |
| | | | | | | |
| Coking coal | Nov 10 | Nov 09 | YOY/M | YTD Nov 10 | YTD Nov 09 | YOY/Total |
| Total | 46 | 75 | -38% | 1,017 | 651 | 56% |
| Korea (DPRK) | 6 | | | 191 | 52 | 270% |
| South Korea | 40 | 37 | 10% | 581 | 333 | 75% |
| Japan | | 38 | | 246 | 184 | 34% |
| Other | | | | 0 | 83 | |
| | | | | | | |
| Steam coal | Nov 10 | Nov 09 | YOY/M | YTD Nov 10 | YTD Nov 09 | YOY/Total |
| Total | 840 | 1,139 | -26% | 8,385 | 11,254 | -25% |
| Hong Kong | | 56 | -100% | 132 | 56 | 135% |
| Taiwan | 381 | 238 | 60% | 2,387 | 3,136 | -24% |
| Japan | 274 | 175 | 56% | 2,440 | 3,025 | -19% |
| Vietnam | | | | 5 | 0 | |
| South Korea | 185 | 669 | -72% | 3,301 | 4,415 | -25% |
| Europe | | | | 119 | 0 | |
| Other | 1 | | | 1 | 622 | -100% |
| | | | | | | |
| Other coal | Nov 10 | Nov 09 | YOY/M | YTD Nov 10 | YTD Nov 09 | YOY/Total |
| Total | 6 | 5 | 37% | 70 | 49 | 44% |
| Malaysia | | | | 1 | 1 | 56% |
| Japan | 1 | 1 | | 29 | 12 | 136% |
| South Korea | 4 | 2 | 115% | 28 | 23 | 24% |
| Indonesia | | 1 | | 5 | 6 | -12% |
| Other | 1 | | | 7 | 7 | -5% |

Эх сурвалж: Chinese Customs Authorities

Хятадын уул уурхайн татварын систем

Өнөөдөр Хятадад ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийг үндсэн гурван хэлбэрээр төлж байна.

1. нөөцийн татвар
2. нөөцийн нөхөн олговорын төлбөр
3. уурхай ашиглалтын эрхийн хураамж

Үүнээс гадна орлогын албан татвар, НӨАТ зэргийг ноогдуулж болно. Хэдийгээр уурхайн ашиглалтын болон хайгуулын лицензийн төлбөр харьцангуй бага ч нэлээн маргаантай асуудлын нэг байдаг. Нөөцийн татварын хэмжээ харьцангуй бага. 2003 оноос эхлэн Хятадын эдийн засгийн өсөлт нь нүүрсний хэрэгцээг нэмэгдүүлж эхлэсэн.

Нүүрсний эрэлт нийлүүлэлтийн тэнцвэргүй байдал нь нүүрсний үнийг янз бүрийн арга замаар байнга өсгөж байдаг. 1999 онд нүүрсний үнэ дунджаар тонн нь 77.44 ам. долл байсан бол 2003 онд өсч 138.89 ам.долл болсон байна. Харин 2009, 2010 онуудад тонн нүүрсний үнэ бараг 300 орчим юань болжээ. Тэгвэл 1984 онд тогтоосон нүүрсний нөөцийн татвар 20 гаруй жил огт өөрчлөгдөөгүй бөгөөд дунджаар нэг тонн нүүрсэнд 0.5 ам.долл-ын татвар ноогдуулдаг. 2005 оны 5-р сард тус улсын 8 мужид нөөцийн татварын хэмжээг нэмэгдүүлж тонн тутамд 2-оос 4 ам.долл-ын хэмжээгээр татвар ноогдуулдаг болсон байна.

Экспортын татварыг коксжих нүүрсэнд л ноогдуулдаг бөгөөд татварын хэмжээ нь тухайн нүүрсний FOB үнийн 25 хувиар тооцож татвар ноогдуулдаг байна. 2008 онд Сангийн сайд Wang Shuai “Манай улсад эрчим хүчний нүүрс болон коксжих нүүрсний нийлүүлэлт хангалтгүй байгаа тул цаашид экспортын татварын талаар авч үзнэ. Коксжих нүүрсэнд ноогдуулж буй экспортын татварын 25 хувийг нэмэгдүүлж 40 хүртэл хувь болгохоор чармайж байна” хэмээн мэдэгдэж байв.

UIH.MN
СУДАЛГААНЫ САН

НҮҮРСНИЙ ЭКСПОРТОНД ХАМААРАХ ТАТВАРЫН ХУВЬ ХЭМЖЭЭНИЙ ТАЛААРХ ЗАРИМ УЛС ОРНЫ ТАТВАРУУДЫН ХЭМЖЭЭНИЙ ХАВСРАЛТ

Хүснэгт 1. Ашигт малтмалын хуулийн 47.4-т заасан нэмэлт төлбөрийн нүүрсний хувь

| № | Бүтээгдэхүүний нэр төрөл | Хэмжих нэгж | Жишиж үнэлэх бүтээгдэхүүн | Зах зээлийн үнийн түвшин /ам.доллараар/ | Бүтээгдэхүүний боловсруулалтын түвшингээс хамаарч үндсэн хувь дээр нэмж ногдуулах хувь | | |
|---|---|-------------|---------------------------|---|--|-----------|--------------|
| | | | | | Хүдэр | Ба-яж-мал | Бүтээгдэхүүн |
| 1 | Боловсруу-лаагүй нүүрс | тн | Нүүрс | 0-25 хүртэл | 0.00 | - | |
| | | | | 25-50 хүртэл | 1.00 | | |
| | | | | 50-75 хүртэл | 2.00 | | - |
| | | | | 75-100 хүртэл | 3.00 | | |
| | | | | 100-125 хүртэл | 4.00 | | |
| | | | | 125 ба түүнээс дээш | 5.00 | | |
| 2 | Баяжуулсан нүүрс (хуурай болон нойтон аргаар технологийн боловсруулалт хийсэн) | тн | Нүүрс | 0-100 хүртэл | - | 0.00 | - |
| | | | | 100-130 хүртэл | - | 1.00 | - |
| | | | | 130-160 хүртэл | - | 1.50 | - |
| | | | | 160-190 хүртэл | - | 2.00 | - |
| | | | | 190-210 хүртэл | - | 2.50 | - |
| | | | | 210 ба түүнээс дээш | - | 3.00 | - |
| 3 | Эцсийн бүтээгдэхүүн (хагас кокс, кокс, хий, шингэн түлш, нүүрс-химийн бүтээгдэхүүн) | тн | Кокс | 0-160 хүртэл | - | - | 0.00 |
| | | | | 160-190 хүртэл | | | 0.50 |
| | | | | 190-210 хүртэл | | | 1.00 |
| | | | | 210-240 хүртэл | | | 1.50 |
| | | | | 240-270 хүртэл | | | 2.00 |
| | | | | 270 ба түүнээс дээш | | | 2.50 |

Ашигласан материал:

1. The History And Future Of Indonesia's Coal Industry: Impact Of Politics And Regulatory Framework On Industry Structure And Performance, Bart Lucarelli, Program On Energy And Sustainable Development , Working Paper #93, July 2010
2. ИНДОНЕЗ УЛСЫН УУЛ УУРХАЙН ТАТВАР, Dr. Supriyadi, 6/28/2011
3. Mining in Indonesia Investment and Taxation Guide , May 2011
4. World Coal Association, Coal Facts, August 2011
5. <http://mining.news.mn/content/106665.shtml>

6. www.coalspot.com
7. <http://www.coalspot.com/news/2239/indonesian-subbituminous-coal-cfr-south-china-swaps-slightly-drop-this-week/>
8. http://www.sourcewatch.org/index.php?title=South_Africa_and_coal
9. <http://pesd.stanford.edu/publications/23082>
10. Jianjun Tu. "Industrial organization of the chinese coal industry". Freeman spogli institute for international studies. Working paper #103 july 2011
11. Christine Retschlag. "Chinese coal industry set to sizzle in 2011". ISSUE 0203 6 January 2011
12. <http://chinawestproducts.com/08/13/china-coal-tax/>
13. <http://articles.economictimes.indiatimes.com/keyword/coking-coal/featured/3>
14. <http://www.eia.gov/todayinenergy/detail.cfm?id=4210>
15. <http://205.254.135.7/coal/annual/>
16. http://www.nma.org/statistics/fast_facts.asp
17. http://www.sourcewatch.org/index.php?title=U.S._coal_exports

* * *

Хавсралт 1

ОХУ -ын экспортын барааны гол нэрийн бараа* (2012 оны эхний 3 сараар)

2012 оын 5-р сарын 11-ний байдлаар

| Барааны нэр төрөл | Нийт | |
|--|-------------|---------------|
| | мянган тонн | сая ам.доллар |
| НИЙТ: | - | 131,302.5 |
| Пшеница и меслин | 3,196.0 | 833.9 |
| Водка, дал 100% спирта | 448,724.3 | 34.7 |
| Фосфаты кальция | 360.6 | 91.8 |
| Руды и концентраты железные | 6,199.8 | 677.1 |
| Уголь каменный | 27,516.4 | 3,039.2 |
| Кокс и полукокс | 466.1 | 115.4 |
| Нефть сырая | 58,822.0 | 46,166.6 |
| Нефтепродукты | 33,684.5 | 25,443.8 |
| Бензин автомобильный | 817.7 | 682.3 |
| Дизельное топливо, не содержащее биодизель | 10,690.3 | 9,644.5 |
| Топлива жидкие, не содержащие биодизель | 18,347.3 | 11,937.2 |
| Газ природный сжиженный, млн.куб.м | 4.9 | 984.6 |
| Газ природный, млрд.куб.м | 53.7 | 18,853.7 |
| Электроэнергия, млн.кВт-ч | 6,222.9 | 333.5 |
| Аммиак безводный | 403.7 | 168.1 |

| | | |
|---|---------|---------|
| Метанол | 355.7 | 99.6 |
| Удобрения минеральные азотные | 2,728.6 | 843.1 |
| Удобрения минеральные калийные | 2,521.0 | 1,052.4 |
| Удобрения минеральные смешанные | 2,388.4 | 1,115.1 |
| Каучук синтетический | 241.6 | 793.0 |
| Лесоматериалы необработанные, 1000 куб.м | 4,384.1 | 408.7 |
| Лесоматериалы обработанные | 2,371.3 | 756.7 |
| Фанера клееная, 1000 куб.м | 394.7 | 216.7 |
| Целлюлоза древесная | 504.7 | 275.2 |
| Бумага газетная | 317.6 | 175.8 |
| Ткани хлопчатобумажные, 1000 кв.м | 9,774.2 | 10.4 |
| Черные металлы | 9,693.3 | 5,781.1 |
| Черные металлы (кроме чугуна, ферросплавов, отходов и лома) | 6,768.3 | 4,243.0 |
| Чугун | 1,160.8 | 504.8 |
| Ферросплавы | 247.7 | 529.8 |
| Полуфабрикаты из углеродистой стали | 3,785.2 | 2,076.8 |
| Прокат плоский из углеродистой стали | 1,691.6 | 1,105.5 |
| Медь рафинированная | 69.6 | 504.2 |
| Никель необработанный | 85.0 | 1,569.8 |
| Алюминий необработанный | 836.8 | 1,737.0 |
| Машины и оборудование | - | 5,809.1 |
| Автомобили легковые, 1000 шт. | 24.4 | 194.4 |
| Автомобили грузовые, 1000 шт. | 3.0 | 89.1 |

Эх сурвалж: <http://www.customs.ru/>

UIN.MN
СУДАЛГААНЫ САН

